**Батлав:БОАЖЯ-ны Хүрээлэн буй орчин байгалийн нөөцийн удирдлагын газрын :**

**Дарга................................../......................../**

**Хэрэгжүүлсэн :**

**“Спейшл Майнинг Сервис”ХХК-ний**

**Гүйцэтгэх захирал:..........................**

**................................./Э.Амарсанаа/**

# ӨМНӨГОВЬ АЙМАГ ЦОГТЦЭЦИЙ СУМ ЦАГААН ОВОО БАГИЙН НУТАГТ БАЙРЛАХ “СПЕЙШЛ МАЙНИНГ СЕРВИС” ХХК-ИЙН “ҮЙЛДВЭРИЙН ЗОРИУЛАЛТААР ТЭСРЭХ БОДИС ҮЙЛДВЭРЛЭХ ҮЙЛДВЭРИЙН ТӨСӨЛ”-Н 2022 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН

Хянасан: БОАЖЯамны ХБОБНУГ-ын
Мэргэжилтэн: ______________________/ Б.Оргилмаа/

Гүйцэтгэсэн:СПЕЙШЛ МАЙНИНГ СЕРВИС ХХК-ийн
БО-ны ажилтан: _____________________/ Б.Ганзориг /

**2022 он**

Гарчиг

1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА
   1.1 Төслийн нэр
   1.2 Төсөл хэрэгжүүлэгч аж ахуй нэгж байгууллагын нэр хаяг
   1.3 Төсөл хэрэгжүүлж буй газрын засаг захиргааны харъяалал
   1.4 Төсөл хэрэгжих орчны газар ашиглалт, дэд бүтцийн хөгжил
   1.5 Хэдэн оноос ажиллаж эхэлсэн
   1.6 Үйл ажиллагааны хэд дэх жилдээ ажиллаж байгаа
   1.7 Цаашид хэдэн жил үйл ажиллагаа явуулах боломжтой тухай
   1.8 Техник тоног төхөөрөмжийн тухай
   1.9 Технологийн дараалал
2. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ
   2.1 Байгаль орчинд үзүүлсэн сөрөг нөлөөлөл
   2.2 Үүсэж болох эрсдлийг тооцож, болзошгүй аюул ослын үед авах хариу арга хэмжээний төлөвлөгөө, биелэлт
   2.3 Байгаль орчны удирдлагын тогтолцоо
   2.4 Байгаль орчны сургалт сурталчилгаа
3. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ  БИЕЛЭЛТ
   3.1 Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт
   3.2 Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний биелэлт
   3.3 Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт
   3.4 Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт
   3.5 Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт
   3.6 Химийн бодисын эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт
   3.7 Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт
   3.8 Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт
   3.9 Олон нийтэд тайлагнах хуваарь, төлөвлөгөөний биелэлт
   3.10 Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр, түүний үр дүнг тайлагнах, хэлэлцүүлэх төлөвлөгөөний биелэлт
4. ХАВСРАЛТ

# 1 ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

## 1.1 Төслийн нэр:

"Үйлдвэрлэлийн зориулалтаар тэсрэх бодис үйлдвэрлэх, худалдаалах, тэсэлгээний ажил, үйлчилгээ үзүүлэх" төсөл:

## 1.2 Төсөл хэрэгжүүлэгч аж ахуйн нэгж, байгууллагын нэр, хаяг:

"Спейшл Майнинг Сервис" ХХК

Регистерийн дугаар: РД:5623529

Хаяг:Улаанбаатар хот , Хан-Уул дүүрэг, 1-р хороо, 19-р хороолол, Чингисийн өргөн чөлөө, “Их Хуралдай” оффисын байр 10 давхар 1006 тоот

**Төсөл хэрэгжүүлж буй газрын засаг, захиргааны харъяалал:**

“Спейшл Майнинг Сервис”ХХК-ний “Тэсрэх бодисын үйлдвэр, тэсрэх материалын агуулахын цогцолбор” нь Өмнөговь аймгийн Цогтцэций сумын Цагаан Овоо багийн нутаг дэвсгэрт, Таван Толгой орд газрын лицензийн талбайд орших ба түүний байршлыг тэгш өнцөгийн координат болон байр зүйн зургаар үзүүлэв.




(Зураг 1).

Таван Толгойн коксжих нүүрсний орд нь Өмнөговь аймгийн Цогтцэций сумын төвөөс баруун урагш 18 км, аймгийн төв Даланзадгад хотоос зүүн тийш 90 км, Улаанбаатар хотоос урагш 550 км-т оршино. Хилийн боомт болох Гашуун Сухайтаас 240 км, Оюутолгойн зэс-алтны ордоос 150км, Цагаан Суваргын зэс-молбидены ордоос 234 км-т тус тус оршино.

(Зураг 2. Байршлын зураг)

"Special Mining Service" тэсрэх материалын байршил үйлдвэрлэлийн зориулалт бүхий барилга байгууламжийн иж бүрэн цогцолборын байршил




## 1.3 Төсөл хэрэгжих орчны газар ашиглалт, дэд бүтцийн хөгжил

Цахилгаан, эрчим хүчний хангамжийн хувьд тэсрэх бодисын үйлдвэрийн бүхий л хэрэгцээг орд газрын эрчим хүчний эх үүсвэрээс авч хэрэглэж байна. Авто замын сүлжээний хувьд сайжруулсан шороон замаар хангагдсан, ойрын үед Даланзадгад болон Цогт-Овоо сум руу хатуу хучилттай замаар холбогдсон.

Мөн эдгээрээс гадна харилцаа холбооны бүх төрлийн / үүрэн телефон, интернэт гэх мэт / үйлчилгээг ашиглах боломж нөхцөл бүрэн бүрдсэн байна.

## 1.4 Төсөл хэрэгжиж эхэлсэн хугацаа:

"Үйлдвэрлэлийн зориулалтаар тэсрэх бодис үйлдвэрлэх, худалдаалах, хадгалах, тэсэлгээний ажил, үйлчилгээ үзүүлэх" төсөл нь 2013 оны 9-р сараас үйл ажиллагаагаа явуулж эхэлснээс хойш одоог хүртэл амжилттайгаар хэрэгжүүлж байгаа ба цаашид орон нутаг, улс орны нийгэм, эдийн засагт зохих хувь нэмэрийг оруулан тогтвортойгоор үйл ажиллагаагаа явуулах зорилт тавин ажиллаж байна.

## 1.5 Төсөл хэрэгжиж буй хугацаа:

Тус үйлдвэр нь 2013 оноос хойш 9 дахь жилдээ тэсрэх бодисын үйлдвэрлэлийн үйл ажиллагаа явуулж байна.

### 1.6  Цаашид хэдэн жил үйл ажиллагаа явуулах боломжтой тухай:

Цаашид Таван Толгойн нүүрсний орд газар дээр уурхайн олборлолт явагдаж байгаа нөхцөлд төсөл хэвийн үргэлжлэх боломжтой.Тус үйлдвэрийн оршин байгаа нутаг дэвсгэрт ажиллаж байгаа Таван толгой, Ухаа худгийн уурхайн Техник Эдийн Засгийн Үндэслэл нь  23 жилээр төлөвлөгдсөн байдаг ба тухайн бүс нутагт уурхайн олборлолтын ажил нэмэгдэх тусам тэсэлгээний ажил, үйлчилгээний эрэлт, хэрэгцээ улам өсөн нэмэгдэх боломжтой юм.

### 1.7 Техник тоног төхөөрөмжийн тухай:

"Үйлдвэрлэлийн зориулалтаар тэсрэх бодис үйлдвэрлэх, худалдаалах, тэсэлгээний ажил, үйлчилгээ үзүүлэх" уг төсөл нь 2022 оны 11 сарын байдлаар доорхи нэр төрлийн машин, техник төхөөрөмжийг үйлдвэрлэл болон худалдаа, үйлчилгээндээ ашиглаж байна (Хүснэгт 1). Мөн эмульсийн үйлдвэр нь “Dyno Nobel” компанийн зураг төсөл дээр тулгуурлан АНУ улсын “Tread Corp” компанийн иж бүрэн тоног төхөөрөмж, түүнд зориулан, АНУ-ын “Lubrizol” компанийн эмульсжүүлэгч бүтээгдэхүүний технологи дээр суурилагдсан болно.Мөн цооног цэнэглэлтийн үйл ажиллагаанд АНУ-ын “Tread Corp” компанийн 3216 маркын цэнэглэгч биеийг Англи улсад үйлдвэрлэгдсэн Scania маркын /6x4/ хэмжээтэй ачигч  машин дээр суурилуулан ашиглаж байна.



Үйлдвэрлэл, ажил үйлчилгээнд ашиглаж буй техник, тоног төхөөрөмжийн жагсаалт: (Хүснэгт-1)

| № | Техник тоног төхөөрөмж | Хэмжээ, даац | Тоо |
|---|---|---|---|
| 1 | Эмульс цэнэглэгч машин | 12 тн | 2 |
| 2 | Эмульс цэнэглэгч машин | 14 тн | 2 |
| 3 | ANFO буюу хуурай цэнэглэгч машин | 16 тн | 1 |
| 4 | Эмульс цэнэглэгч машин /HOWO/ | 20 тн | 3 |
| 5 | Хайргаар түгжигч HOWO | 13 тн | 2 |
| 6 | Түлшний машин HOWO | 20000л | 1 |
| 7 | Manitao (Сэрээт өргөгч) | 1,5 | 1 |
| 8 | Порклифт | 2 | 1 |
| 9 | БоБкат (Бага оврын түрэгч) | 1 | 1 |
| 10 | Ford F450 | 5 | 1 |
| 11 | Үйлчилгээний суудлын машин /Land 79/ | 5 | 5 |
| 12 | Ачааны автомашин /Mighty / | 4тн | 2 |
| 13 | Үйлчилгээний суудлын машин / Land 76/ | 5 хүний | 1 |
| 14 | Үйлчилгээний суудлын машин /Long 78/ | 8 хүний | 5 |
| 14 | Үйлчилгээний нийтийн автобус/ KIA/ | 45 хүний | 1 |

**1.8 Үйлдвэрлэлийн технологийн дараалал:**

**Аммиакийн шүү уусгах ба уусмал хадгалах модуль:**

Модуль нь аммиакийн шүү уусгах болон исэлдүүлэгчийн бэлэн уусмал хадгалах зориулалттай нөөцийн сав юм. Энэхүү нөөцийн сав нь дараахь техникийн үзүүлэлттэй:

- Уусмалын шүлтлэг (pH) нь 3.59-3.61 болтол цууны хучил (Acetic Acid) болон содын давс нэмж өгнө. Acetic Acid 60%-75%, Ус 40%-25%
- Уусмалын хийжүүлэгч чанарыг катализжуулахад Thiourea( $CH_4N_2S$) нэмж өгнө
- Усыг уусмалын тогоонд хийж цельсийн 40 градус болтол халаана. Үргэлжлүүлэн аммиакын шүүг бага багаар нэмж, үргэлж хутгах байдлаар уусгах ба халууныг 15°-аас доош буулгаж болохгүй. Ийнхүү аммиакын шүү хийж хутгах байдалд 55° болтол халаана. Уусмал аяндаа жигд өтгөрч, түүний дусал үүсгэх цэг (fudge point) нь 44°-46°-т бүрэлдэнэ.

**Эмульс бэлтгэх модуль:**

Эмульс бэлтгэх ажлыг уусмалын фазаас эхлэн түүнээс насосоор соруулна.Бэлтгэх тогоонд юүлэнэ. Уусмал юүлэгдэж дуусахад эмульс бэлтгэх ажлын насосыг ажиллуулан уусмалыг эргэлтэнд оруулна. Ийнхүү түлш ба уусмалын фаз

холигдон жигд өтгөн байдалд ормогц буцаан эмульс хадгалах тогоонд шахна. Ийнхүү эмульс хадгалах тогоог хаалтаар нь хааж түүний өтгөрөлтийг шалгаж үзнэ.

**Тосны модуль:**

Дулаан тусгаарлагч бүхий үлээгч салхилуур, уурын халаагч зэргээр тоноглогдсон модульд доорхи 3 модуль байрлана:

- Эрчим хүчний модуль: - A
- Цахилгааны модуль: - B
- Тосны модуль: - C

**Ус болон хийжүүлэгч нэмэгдлийн модуль:**

Эмульсийн үйлдвэрийн ус хангамж нь нэгдсэн нэг системтэй байна. Ус цооногоос гүний насосоор усны модуль руу шахагдах ба энд ус цэвэрлэх системийн тусламжтайгаар цэвэрлэгдэж, химийн найрлагаараа унданд хэрэглэхүйц чанартай болно. Усыг шаардлагатай хэмд хүртэл халааж, тэнд байрлах насоснуудын тусламжтайгаар модульт, хольж эмульсжүүлэх зориулалтын төхөөрөмж, цэнэглэгч машиныг ачаалах талбай зэргийг усаар хангана.

Дулаан тусгаарлагчтай модуль нь цооногоос ирж байгаа усыг цзвэрлэх, модуль дахь исэлдүүлэгчийн уусмал бэлтгэх зэрэг үйлдвэрлэлийн технологийи бүх хэрэгцээний болон цэнэглэгч машинд өгөхөөс өмнө бэлтгэж халаах, түүнчлэн хийжүүлэгч нэмэгдлийг цэнэглэгч машинд халааж өгөхөд зориулагдсан болно.

Модуль нь хаалтаар тусгаарлагдсан 2 хэсгээс бүрдэнэ:

1. Ус цэвэрлэх баллон халаах модуль,

2. Цэнэглэгч машинд ачаалах хийжүүлэгч нэмэгдлийг бэлтгэх модуль

# 2 ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

## 2.1 Байгаль орчинд үзүүлсэн сөрөг нөлөөлөл:

**Агаар:**

Тус үйлдвэрийг ашиглах явцад их хэмжээний нутаг дэвсгэрийг хамарсан хүн ам, амьтан, ургамал, хөрс, усанд их хэмжээгээр нөлөөлөхүйц сөрөг нөлөөлөл үүсээгүй боловч дараахь багахан хэмжээний сөрөг нөлөөлүүд үүссэн болно.

- Салхины хүч, агаарын чийг, тээврийн үйл ажиллагаанаас хамааран агаар мандалд гарах тоосны хэмжээ хуурайшлын үед нэмэгдэх, зөөгдөх
- Тээврийн хэрэгслийн хөдөлгөөн нэмэгдэх нь агаарын чанар, шуугианы бохирдлын түвшинг ихэсгэнэ.
- Үйлдвэрлэлд ашиглагдаж буй химийн бодисуудаас эвгүй үнэр агаарт тархах зэрэг болно.

**Газрын гадарга, хөрс:**

Тэсрэх бодисын үйлдвэр, тэсрэх материалын агуулахын цогцолбор нь нийт 5га талбайг тойруулан татсан хашаан дотор байрлах ба уг 5 га талбайн хөрс болон газрын гадарга нөлөөлөлд өртсөн.

Мөн тээвэр, зөөвөртэй холбогдон хөрс, ургамлан бүрхэвч бага хэмжээгээр өртсөн.

**Ус:**

Технологийн шингэн хаягдлыг холбогдох дүрэм, журам, стандарт болон "Ухаа худаг ус хангамж"ХХК-тай хийсэн гэрээний дагуу цэвэрлэх байгууламжид тогтмол нийлүүлснээр гүний усанд сөрөг нөлөөлөл үзүүлээгүй болно. 2017-оны 11-р сараас өмнө үйлдвэрлэлийн хэрэглээнд Өмнөговь аймгийн Цогтцэций сумын төвд орших "Ухаа худаг ус хангамж"ХХК-иас зөөврөөр ус авч ашиглаж байсан ба 2017 оны 11 сараас хойш үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд өөрийн үйлдвэрийн дэргэд гаргасан гүний худгийг тогтмол ашиглаж байна. Тус гүний худгийн болон ус ашиглахтай холбоотой материалыг хавсралтад оруулав.

**Ургамал:**

Тээврийн хэрэгсэл болон хүний үйл ажиллагаанаас ургамлан нөмрөг талхлагдаж улмаар хөл газрын ургамал тархах болсон.

**Амьтан:**

Тээврийн хэрэгслийн дуу чимээ, үйлдвэрийн зам талбай, барилга байгууламж барих үед тухайн газрын хөрсний амьд организм, шавьж дайжин, устаж үгүй болсон ба мэрэгч амьтад үйлдвэрийн хашаа болон ойр орчимд нутаглаж байдаг.

**Хатуу хог хаягдал, аюултай болон хортой хаягдал:**

"Спейшл Майнинг Сөрвис" ХХК нь 2021 онд "Тэгш дүүрэн тохижилт" ОНӨААТҮГ- тай гэрээ хийн хог хаягдлын хүний эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх хортой нөлөөллийг арилгах, хог хаягдлыг тээвэрлэх, цугуулах, төвлөрсөн цэгт хүргэх үйл ажиллагааг явуулж байна. Мөн хүн болон байгаль орчинд хор хөнөөл учируулах хортой аюултай хог хаягдлыг устгуулахаар мэрэгжлийн байгууллага болох “Цэцүүх трейд”ХХК-тай хамтран ажиллах гэрээ байгуулж төвлөрсөн цэгт нь хүргэж өгч ажиллаж байна.

**Аюул гамшиг, осол, эрсдэлийн тухай тэмдэглэл:**

Төсөл хэрэгжих хугацаанд болон өнгөрч буй 2021 онд тус тэсрэх бодисын үйлдвэр болон үйлдвэрийн бүсд ямар нэгэн аюул, гамшиг, осол эндэгдэл гараагүй болно.”Спейшл Майнинг Сервис”ХХК-нь холбогдох хуульд заасны дагуу өөрийн эзэмшлийн “Тэсрэх бодисын үйлдвэр, тэсрэх материалын агуулахын цогцолбор”-ын хэмжээнд “Гамшгаас хамгаалах төлөвлөгөө”-г боловсруулан гаргаж, мэргэжлийн байгууллагаар хянуулан тогтмол хамтран ажиллаж байна.

**2.2 Үүсэж болох эрсдлийг тооцож, болзошгүй аюул ослын үед авах хариу арга хэмжээний төлөвлөгөө, биелэлт:**

”Спейшл Майнинг Сервис”ХХК-ний “Тэсрэх бодисын үйлдвэр, тэсрэх материалын агуулахын цогцолбор”-ын хэмжээнд компанийн болон үйлдвэрийн удирдлага аливаа осол аваарь, эрсдэлтэй тохиолдлоос ямагт урьдчилан сэргийлэх арга хэмжээг тухай бүр авч хэрэгжүүлэн ажиллаа.

Үүнтэй холбоотой авах арга хэмжээний төлөвлөгөөг “Гамшгаас хамгаалах төлөвлөгөө”-нд нэг бүрчлэн тусган, хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхой заан хэрэгжүүлж байгаа ба аливаа эрсдлээс урьдчилан сэргийлэх чиглэлд авах арга хэмжэээний төлөвлөгөөг “Тэсрэх бодисын үйлдвэр, агуулахын гамшгийн эмзэг байдал, эрсдлийн үнэлгээ”-нд тусган тогтмол хяналт тавин ажиллаж байгаа болно.Үйлдвэрлэлийн болон тэсэлгээний ажил, үйлчилгээний ажлуудад гарах аливаа сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээг тухай бүр авах, хянах, эрсдэлийг үнэлэх ажлыг тухайн ажлын байр тус бүрт гарган хяналт тавьж ажилласан болно.

**2.3 Байгаль орчны удирдлагын тогтолцоо (БОУТ)**

"Спейшл Майнинг Сервис" ХХК нь “Байгаль орчны удирдлагын тогголцоо - Шаардлага, хэрэглэх арга заавар MNS ISO 14001:2005” буюу Олон улсын ISO 14001 стандартын шаардлагыг хангасан байгаль орчинд ээлтэй байгууллага болох зорилтын дагуу холбогдох, дүрэм, журам, үйл ажиллагааны хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулан, хэрэгжүүлж, хяналт тавин ажиллаж байна.

Байгаль орчны удирдлагын тогтолцооны хүрээнд үйлдвэрлэлийн болон өдөр тутмын үйл ажиллагаандаа дагаж мөрдөх журмуудыг боловсруулан хэрэгжүүлж байна. Үүнд:

- ✓ БОМС-ийн удирдамж, үндсэн дүрэм
- ✓ Гэрээт компани болон зочдын байгаль орчны дагаж мөрдөх журам
- ✓ Хог хаягдлын журам
- ✓ Асгаралтын журам
- ✓ Химийн бодис материалтай харьцах журмууд
- ✓ Химийн бодисуудын хор аюулын лавлах мэдээлэл
- ✓ Химийн бодисуудын лавлагаа
- ✓ Тэсрэх бодис, тэслэх хэрэгслийн лавлагаа, аюулын мэдээлэл
- ✓ Эмульс үйлдвэрлэлийн стандарт ажлын журам
- ✓ Үйлдвэрлэлийн үйл ажиллагаатай холбоотой стандарт ажлын журмууд зэрэг баримт бичгийг үйлдвэрлэлийн дотоод үйл ажиллагаанд мөрдөж, хэрэгжүүлэн ажиллаж байна.

**2.4 Байгаль орчны сургалт, сурталчилгаа**

Тэсрэх бодисын үйлдвэрт очиж буй үндсэн болон гэрээт компанийн ажилтнууд, зочдыг байгаль орчны зааварчилгаа, сургалт, танилцуулгад хамруулдаг бөгөөд байгаль орчны чиглэлд хийж хэрэгжүүлж байгаа өөрсдийн ажлыг танилцуулгын нэг хэсэг болгон заавал үзүүлж танилцуулан ажилладаг.

- Байгаль орчны сургалтын зорилго нь Байгаль орчны талаар мөрдөж буй хууль, дүрэм, журмуудыг компаний үндсэн ажилтан болон гэрээт байгууллагын ажилчдад танилцуулж мөрдүүлэх, байгаль орчны талаархи үйл ажиллагааны чиглэл, зорилгыг танилцуулах
- Үйлдвэрлэлийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах чиглэлээр хэрэгжүүлэх үйл ажиллагаа, тэдгээрийг мэдээллэх, ажилчдын үүрэг оролцоог таниулах, нэмэгдүүлэхэд оршино.
- Үйлдвэрлэлд хэрэглэгдэж байгаа химийн бодисуудын хор, аюулын талаархи мэдлэг олгох, химийн бодистой зөв харьцаж ажиллах дадал, зуршил эзэмшүүлэх, ашиглалт, хэрэгцээнд хяналт тавих, бүртгэх, хадгалалт, хамгаалалттай холбоотой мэдээллээр хангах зэрэг сургалт, зааварчилгааг тухай бүр өгч ажиллаж байна.
- Мэрэгжлийн эрх бүхий байгууллагаас зохион байгуулж байгаа “Химийн блдистой харьцаж ажилладаг ажилтны ХАБЭА-н сургалт”-д инженер техникийн ажилтан болон, туслах ажилтнуудыг хамруулан ажилласан.

## 3 . БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ:

Байгаль Орчны Менежментийн Тайланг Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай Монгол Улсын хууль, БОАЖЯ-ны сайдын 2019 оны 10 дүгээр сарын 25-ны өдрийн А-618 тоот тушаалын хавсралтад заасан журмын дагуу боловсруулан танилцуулж байна.

"Спейшл Майнинг Сервис" ХХК-ийн байгаль орчныг хамгаалах бодлогын гол зорилго нь "Тэсрэх бодисын үйлдвэрийн технологи үйл ажиллагаа болон тэсрэх бодис үйлдвэрлэхэд ашиглагдах химийн бодисуудаас байгаль орчинд учруулах сөрөг нөлөөллийг тодорхойлох, түүнийг бууруулах, арилгах арга хэмжээ, шаардагдах хөрөнгө зардлыг төлөвлөх, химийн хорт болон аюултай бодисыг зохистой ашиглах талаар зөвлөмж боловсруулах, мөн үйлдвэрлэлийн явцад мөрдөж ажиллах байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр боловсруулан БОАЖЯ-аар баталгаажуулсан төлөвлөгөөг хэрэгжүүлэх" -д оршино.

2022 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөгөөр тэсрэх бодисын үйлдвэр байрлаж буй нутаг дэвсгэрийн орчмын байгалийг хамгаалах үйл ажиллагааны гол зорилт, авч хэрэгжүүлэх арга хэмжээний хэм хэмжээг тогтоож өгсөн болно.

Байгаль орчныг хамгаалах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг холбогдох журам, ерөнхий үнэлгээгээр тавигдсан шаардлагын дагуу тодорхойлж тусгав. Эдгээр зардлууд нь байгаль орчныг хамгаалах ажлын шууд зардлууд бөгөөд түүнтэй холбогдон гарах бусад зураг төслийн буюу туслах чанарын ажлуудын зардал болон үйлдвэрлэлийн үйл ажиллагааны явцад хийгдэх ажлын зардлууд тусгагдаагүй болно. Манай компани нь үйлдвэрлэлийн газартаа анх 2013 онд “Байгаль Орчины Нөлөөллийн Нарийвчилсан Үнэлгээ”-г “Нью ларус” ХХК-р гүйцэтгүүлэн БОНХЯ-р батлуулан хэрэгжүүлж ажиллаж байсан ба 2020 онд “Дэлгэр Консалтинг”ХХК-р нэмэлт тодотгол хийн дүгнэлт тайлан гаргуулан ажилласан.

## 3.1 Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт:

### Агаарын чанар:

| 2022 онд Байгаль орчныг хамгаалах чиглэлээр хийхээр төлөвлөсөн арга хэмжээ | 2022 онд хийж хэрэгжүүлсэн ажлын гүйцэтгэлийн тайлан | Гүйцэтгэсэн хугацаа | Нийт зардал,₮ |
|---|---|---|---|
| Үйлдвэрийн эргэн тойрны нутаг дэвсгэрийг хамруулан тоосны хяналт, шинжилгээг хөтөлбөрийн дагуу хийнэ. ОХШХ-т тусгагдсан. | Өмнөговь аймгийн Ус Цаг Уур Орчны Шинжилгээний төв лаборатори тэсрэх бодисын үйлдвэрийн орчны агаарын шинжилгээний болон орчин дахь агаарын тоосны хэмжилтийг хийлгэж баримтжуулсан. | 2022 оны 07-р сарын 25-нд | ОХШХ-ийн зардалд тусгагдсан. 90000 ₮ |
| Үйлдвэрийн орчны газар эвдрэхээс аль болох зайлсхийж, олон салаа зам гаргахгүй байхад хяналт тавина. Зөвхөн батлагдсан зөвшөөрөгдсөн маршрутаар уурхай болон үйлдвэр, кемпийн хооронд явна. Нийт ажилтнуудад холбогдох сургалтыг явуулна. | “Эрдэнэс Таван Толгой”ХК болон “Тавантолгой”ХК-иудын уурхай руу тэсрэх бодис тэсэлгээний хэрэгсэл тээвэрлэх, кемпээс үйлдвэр рүү ирэх, очихдоо тогтмол Цогтцэций сум уурхай хооронд сайжруулсан төв замаар хүн болон ачаа тээвэрлэж байна. Аливаа тээвэрлэлтийн үед үйлдвэрийн удирдлага, байгаль орчны ажилтны зүгээс тогтмол хяналт тавин ажиллаж байна. | Үйл ажиллагааны хугацаанд тогтмол хянаж хэрэгжүүлэн ажиллаж байна. | Дотоод зардал |
| Төслийн хэмжээнд хэрэглэж байгаа техник хэрэгслүүдийн утаа Монгол Улсын болон олон улсын холбогдох стандарт./ Бензин хөдөлгүүрийн утааны стандарт (MNS 5031:2003) дизель хөдөлгүүрийн стандарт (MNS 5014:2003)./ -д нийцсэн байна. | 2022 онд нийт 28 машиныг техникийн үзлэгт хамруулж холбогдох хуулийн дагуу агаар бохирдуулсны төлбөрийг төлсөн | Үйл ажиллагааны хугацаанд тогтмол хянаж хэрэгжүүлэн ажиллаж байна | Дотоод зардал |

### Газрын гадарга, хөрс:

| 2022 онд Байгаль орчныг хамгаалах чиглэлээр хийхээр төлөвлөсөн арга хэмжээ | 2022 онд хийж хэрэгжүүлсэн ажлын гүйцэтгэлийн тайлан | Гүйцэтгэсэн хугацаа | Нийт зардал,₮ |
|---|---|---|---|
| Тээврийн хэрэгслийг маршрутын биш замаар явахыг хориглосон таних тэмдэг бүхий самбаруудыг байрлуулах, онцын шаардлагагүй шороон замуудыг хаах. Төлөвлөгөөнд тусгагдсан (200,000.00 төг) | 2022 онд уурхай сумын төвийн хоорондын сайжруулсан замаас “Спейшл Майнинг Сервис”ХХК-ний үйлдвэр рүү эргэсэн зөвхөн нэг зам гаргаж, дундаас салаалсан замуудыг хааж, хөмсөг тавих арга хэмжээг авч хэрэгжүүлсэн. Замын болон зам орчмын аюулгүй тэмдэглэгээг шинээр хийх, сайжруулах ажлыг гүйцэтгэсэн. | 2022 оны 6 сарын 7-нд, 2022 оны 10 сарын 3-нд | 200,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| Талбайн зориулалттын хогийн цэгээс гадагш элдэв хог хаягдал хаяхгүй, газрын хөрсийг эвдэхгүй, хөндөхгүй байх арга хэмжээг тогтмол хэрэгжүүлэх, нийт ажилчдад сургалт зохион байгуулах. | Үйлдвэрлэлийн явцад гарсан сав , Баглаа боодол болон ахуйн хог хаягдлыг хамтран ажиллах гэрээний дагуу сумын хогийн цэгт нийлүүлсэн ба Аюултай хог хаягдлыг мэрэгжлийн устгах байгууллага буюу “Цэцүүх трейд” ХХК-нд өөрийн зардалаар тээвэрлэн хүргэж өгч устгуулж ажилласан. Ахуйн хог хаягдлыг “Тэгш дүүрэн тохижилт” ОНӨААТҮГ-д гэрээний дагуу хүргүүлж устгуулсан. | 2022 оны 1 сараас 11-р сарын хатуу болон шингэн хог хаягдлын нийт төлбөр | 3,420,000.00 |
| Химийн бодис болон үйлдвэрийн бохирын хаягдал хөрсөнд нэвчихээс сэргийлэн тогтмол хяналт тавьж, урьдчилан сэргийлэх арга хэмжээг тухай бүр хэрэгжүүлэн ажиллана. | Химийн бодисын хадгалалт, хамгаалалтын асуудлыг агуулахын нярав тогтмол хянан ажиллаж байгаа ба ХАБ-ын ажилтан, химич инженер нар байнга үзлэг, шалгалт хийж анхаарч ажиллаж байна.Үйлдвэрийн шингэн бохирын хаягдлыг үйл ажиллгааны явцад тогтмол хянаж, хаягдлын танк дүүрэхээс өмнө зориулалтын машинаар соруулан цэвэрлэх байгууламжид нийлүүлж байна. | Үйл ажиллагааны явцад тогтмол хянаж ажиллаж байна. | 11,400,000.00 |
| Хөрсний бохирдлыг тогтоох зорилгоор хөрснөөс дээж авч орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт заасан хугацаанд шинжлүүлэх. ОХШХ-т тусгагдсан. | 2022 оны 07-р сарын 25-нд Цаг Уур, Орчны шинжилгээний газар байгаль орчин хэмжил зүйн төв лабораторийн ажилтанаар хийлгэсэн. | 2022 оны 07-р сарын 25-нд | 120,000.00 |

## Гадаргын болон газрын доорх ус:

| 2022 онд Байгаль орчныг хамгаалах чиглэлээр хийхээр төлөвлөсөн арга хэмжээ | 2022 онд хийж хэрэгжүүлсэн ажлын гүйцэтгэлийн тайлан | Гүйцэтгэсэн хугацаа | Нийт зардал,₮ |
|---|---|---|---|
| Хортой болон аюултай химийн бодис хадгалж буй агуулахын шал, суурийг урьд жилүүдэд шингэн үл нэвтрүүлэгч, тухайн химийн бодисын ХАЛМ-/ Хор аюулын лавлах мэдээлэл/-д заасны дагуу үл идэгдэх материалаар хийснийг тогтмол хянаж, шаардлагатай тохиолдолд сэргээн засварлах, урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэхэд шаардлагатай материал бэлэн байлгана. 2018 онд химийн бодисын агуулахын гадна талбай, дизель түлшний агуулахын талбай зэргийг бүрэн цементэлсэн ба 2022 онд шаардлагатай бусад талбайнуудыг мөн цементэлж байгаль орчинд нөлөөлөх аливаа сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээг тогтмол хэрэгжүүлэн ажилласан. /2022 онд 200,000 төгрөг | Химийн бодис хадгалах агуулахын барилгыг зургийн дагуу барьж эхлүүлэсэн, Түүхий эдийн агуулахын зураг төслийг батлуулан ажиллаж байна. Мөн шинээр стандартын дагуу 3ш агуулахыг барьж Улсын коммис ажиллуулан хүлээж авсан. | 2022 онд эхэлсэн | Компани өөрийн зардлаар дотоод зардлаар |

| | | | |
|---|---|---|---|
| төсөвлөгдсөн/ | | | |
| Аюултай хортой материалын менежментийг чанд мөрдөж ажиллана. Аюултай болон хортой материалын менежментийн төлөвлөгөөнд тухайн бодис, материалыг алдагдахаас бүрэн сэргийлсэн хадгалалтын нөхцөлийг тодорхойлох, тэдгээрийг алдагдаж, гоожсон тохиолдолд түүнийг хэрхэн цуглуулж, аюулгүй болгох, тээвэрлэх, зайлуулах асуудлыг зохистой шийдвэрлэн үйл ажиллагааны явцад тогтмол хяналт тавьж ажиллана. | Үйлдвэрлэлд хэрэглэгдэж байгаа хортой болон аюултай бодисуудын хор аюулын лавлах мэдээллийг химийн бодис тус бүрийн агуулахууд дотор байршуулсан ба тухайн химийн бодистой хэрхэн харьцаж ажиллах, аюулгүй байдлыг хэрхэн хангах талаархи сургалтыг дотооддоо улирал бүр химич инженер болон ХАБ-ын ажилтны зүгээс зохион байгуулж ажиллаа. Мөн энэ онд “Грийн химистри”ХХК-ний гаргасан Иж бүрдэл болон асгаралт саармагжуулах бодис худалдан авч байршуулсан. Тос маслын хуримтлуулах цэгийг ажиглалтанд оруулж ажилласан. | 2022 оны 3 сард | Дотоод зардал |
| Үйлдвэрийн зориулалтаар ашиглаж буй гүний худгийн усны шинжилгээг орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт тусгасны дагуу хийлгэнэ. Шаардлагатай тохиолдолд нэмэлтээр болон дахин шинжлүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэн ажиллана. | Өмнөговь аймгийн УЦУОШТөвөөр 7 сард хийлгэсэн. | 2022 оны 7 сарын 25-нд хийлгэсэн | 80,000.00 |

**Ургамлан нөмрөг:**

| 2022 онд Байгаль орчныг хамгаалах чиглэлээр хийхээр төлөвлөсөн арга хэмжээ | 2022 онд хийж хэрэгжүүлсэн ажлын гүйцэтгэлийн тайлан | Гүйцэтгэсэн хугацаа | Нийт зардал,₮ |
|---|---|---|---|
| Газар хөндөх шаардлага гарсан тохиолдолд орон нутгийн холбогдох байгууллага, албан тушаалтнаас зохих зөвшөөрлийг авч ажиллах бөгөөд ургамалан нөмрөгтэй холбоотойгоор аливаа асуудал үүссэн тохиолдолд мэргэжлийн ургамал судлаачийн гаргасан дүгнэлт, заавар зөвлөмжийг мөрдөж ажиллана. | 2022 онд үйлдвэрийн бүсэд ямар нэгэн байдлаар газар хөндөх, ухах тохиолдол гараагүй тул орон нутгийн холбогдох байгууллагаас зөвшөөрөл авах шаардлага гараагүй болно. | - | - |

**Амьтны аймаг:**

| 2022 онд Байгаль орчныг хамгаалах чиглэлээр хийхээр төлөвлөсөн арга хэмжээ | 2022 онд хийж хэрэгжүүлсэн ажлын гүйцэтгэлийн тайлан | Гүйцэтгэсэн хугацаа | Нийт зардал,₮ |
|---|---|---|---|
| Монгол улсын улаан ном, Бүс нутгийн болон Олон улсын улаан данс, бусад хууль тогтоомж, гэрээ конвенциор хамгаалагдсан ховор, нэн ховор зэрлэг амьтдын талаар сургалтыг компанийн ажилтнуудад зохион байгуулж аливаа ан амьтныг хамгаалах, хайрлах, эрсдлээс сэргийлэхэд чиглэсэн арга хэмжээг авч хэрэгжүүлэн ажиллана. | 2022 онд ажилчдад хүрээлэн буй Байгаль орчин, түүний бүрдэл хэсгүүдийн талаар яриа, таниулга, зааварчилгааг амаар өгч ажилласан ба зуны улиралд мэрэгч амьтадын байршил, орчны нөлөөлөлтэй холбогдуулан ажиглалт явуулсан болно.Үйлдвэрийн | 2022 оны 3-р сарын 30-нд | 750,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| | бүс орчим байгаа мэргэч амьтад үйлдвэрлэлийн одоо явагдаж буй үйл ажиллагаанаас шалтгаалан дайжих, хөдөлгөөнд орох үзэгдэл илрээгүй болно. Энэ ажлын хүрээнд сумыг Байгаль Орчны ажилтнуудтай хамтран зэрлэг ан амьтадад өвс тавих ажлыг зохион байгуулсан. | | |
| Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний нийт зардалын төсөв: | Нийт төлөвлөсөн зардал: 500,000 | 2022 онд сөрөг нөлөөллийг бууруулахад зарцуулсан зардал: | 750,000 |

### 3.2 Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө:

| 2022 онд Байгаль орчныг хамгаалах чиглэлээр хийхээр төлөвлөсөн арга хэмжээ | 2022 онд хийж хэрэгжүүлсэн ажлын гүйцэтгэлийн тайлан | Гүйцэтгэсэн хугацаа | Нийт зардал,₮ |
|---|---|---|---|
| Ногоон байгууламж бий болгох | 3000 мянган модыг Цогтцэций сумын Өгөөмөр талбай болон ЭТТ ХК-ний Шинэ оффисийн бүсэд тарьсан. | 2022 оны 5 сар 10 сар | 23,438,885 |
| Зөөлөн хөрстэй, элэгдэлд амархан орох зам, талбайг болон ашиглалтын явцад эвдрэлд орж хучаас нь муудсан зам талбайг шигшсэн хайргаар хучиж, шаардлагатай зам талбайг цементлэх зэргээр байгаль орчинд нөлөөлөх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээг тогтмол хэрэгжүүлэн ажиллана. /2022 оны БОМТ-нд 1,200,000.00 төгрөг төсөвлөсөн/ | 2022 онд үйлдвэрийн орчны зам талбайг сайжруулах, хөрсний бохирдол, эвдрэл, урьдчилан доройтлоос сэргийлэх зорилгоор дараахь ажлуудыг хийж гүйцэтгэсэн болно.Үүнд:<br>1. Үйлдвэр, агуулахын цогцолборт нэвтрэх гадна хаалга орчмын талбайг хайргаар хучсан.<br>2. Зам талбай, зогсоолын хэсгийн тэмдэг тэмдэгдэгээг шинэчилж, сайжруулсан.<br>3. Зогсоолыг хайргаар хучсан<br>4. Байнгын 1 замаар явах краныг угсарч ашиглалтад оруулсан. | 2022-оны 3-сараас 8-р сарын хооронд эдгээр ажлыг өөрийн нөөц бололцоог ашиглан хийж гүйцэтгэсэн. | Дотооддоо төлөвлөсөн ажлаа хийж гүйцэтгэсэн бөгөөд 2022 онд төсөвлөсөн зардлаас хэд дахин илүү зардал гарсан тул гүйцэтгэлийг төлөвлөсөн зардлаар тооцов. |
| Үйлдвэрийн барилга байгууламж, зам талбайд эвдэгдсэн газруудын хөрсийг нөхөн сэргээх. /2022 оны БОМТ-нд 150,000.00 төгрөг төсөвлөсөн/ | Үйлдвэрийн дэргэд байрлах машин угаалгын цэгийн орчмын газар эвдрэлд орж эхэлсэн тул тухайн газрыг хамгаалах зорилгоор 6 удаа | 2022 оны 4,8,11-р сард хайрга дэвссэн | 4,992,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| | 8 машин хайрга /80м3/ дэвсэж эвдрэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлсэн. | | |
| Нийт дүн Нийт төлөвлөсөн зардал: 750,000.00 | | 2022 онд нөхөн сэргээлтэд зарцуулсан зардал: | 4,236,000.00 |

**3.3 Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт**

Газрын тос, уул уурхай, цацраг идэвхит ашигт малтмалын төслийн хувьд биологийн олон янз байдлын дүйцүүлэн хамгаалах арга хэмжээг авч хэрэгжүүлдэг ба 2021 онд манай төслийн хувьд дүйцүүлэн хамгаалах арга хэмжээг авч хэрэгжүүлэх гараагүй шаардлага болно.

**3.4 Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт**

Төсөл хэрэгжиж буй нутаг дэвсгэр, түүний ойр орчимд нүүлгэн шилжүүлэх шаардлагатай, тус төслийн нөлөөлөлд өртөж болзошгүй төв, суурин газар, малчин өрх айл, обьект байхгүй болно.

**3.5 Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт**

Тухайн төсөл хэрэгжиж буй орчинд ямар нэгэн түүх, соёлын дурсгалт зүйл илрээгүй бөгөөд Байгаль орчны аудитын зөвлөмжийн дагуу төсөл хэрэгжиж буй талбайд археологийн болон палеонтологийн судалгааны ажлыг 2017 онд хийлгэж холбогдох дүгнэлтийг гаргуулсан. Цаашдаа төсөл хэрэгжих явцад түүх соёлын дурсгалт зүйл илэрвэл холбогдох мэргэжлийн байгууллагуудад болон орон нутгийн засаг захиргаа, мэргэжлийн хяналтын байгууллагад хандаж авран хамгаалах арга хэмжээг авна.

**3.6 Химийн бодисын эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт:**

**Химийн бодисыг хадгалах:**

| 2022 онд Байгаль орчныг хамгаалах чиглэлээр хийхээр төлөвлөсөн арга хэмжээ | 2022 онд хийж хэрэгжүүлсэн ажлын гүйцэтгэлийн тайлан | Гүйцэтгэсэн хугацаа | Нийт зардал,₮ |
|---|---|---|---|
| Хадгалж байгаа химийн хорт болон аюултай бодисын сав, баглаа боодолд тухайн бодисын нэр, анхааруулах тэмдэг, аюулын шинж чанарыг тод, томруун бичсэн хаяг шошготой байлгаж харагдахуйц байрлалд тодоор зурж байрлуулж тогтмол хяналт тавьж байна. /2022 оны БОМТ-нд 150,000.00 төгрөг төсөвлөсөн/ | Химийн бодисын агуулах тус бүрт тухайн химийн бодисын “Хор Аюулын Лавлах Мэдээлэл”-ийн самбарыг байршуулсан ба үйлдвэрийн лабораторид мөн байршуулсан болно. Хөрс саармагжуулах талбайг би болгосон. | Үйл ажиллагааны явцад тогтмол хяналт тавин ажилладаг | Химийн бодисуудын Хор Аюулын Лавлах самбар шинэчилж байршуулахад 3,500,000.00 |
| Хоорондоо нийцэхгүй бодисуудыг аюулгүй байдлыг хангаж тус тусд нь хадгална. Бүх химийн бодис, ялангуяа шатамхай шингэнийг халаалтын хэрэгсэл, цахилгааны эх үүсвэр, системээс хол, нарны гэрэл шууд тусахааргүй нөхцөлд хадгална. | Манай компанийн химийн бодисын агуулахууд нь нэр, төрөлөөр нь тус тусд нь, зохих нөхцөл, шаардлагын дагуу хадгалах зориулалттай ба химийн бодисыг ашиглах, хэрэглэх үед аюулгүй ажиллагааны заавар, дүрмийн дагуу аливаа эрсдлээс бүрэн сэргийлж, хяналт тавин ажиллаж байна. Мөн нэмж химийн бодис, түүхий эдийг стандартын дагуу хадгалах 3ш агуулахыг барьж Улсын коммист хүлээлгэж өгсөн. | Үйл ажиллагааны явцад тогтмол хяналт тавин ажилладаг. | Дотоод зардал |
| Тэсэрч дэлбэрэх, галын аюултай бодисуудыг нарны шууд тусгалаас хамгаалсан байгууламжид байрлуулж, хамгаалалтын хатуу дэглэм тогтоож, тогтмол хяналт тавьж ажиллана. | Тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн агуулахууд нь аюулгүй байдлын бүх нөхцөл шаардлагыг бүрэн хангаж, холбогдох газраас авсан зөвшөөрлийн дагуу үйл ажиллагаандаа ашигладаг агуулахууд юм.Мөн тус агуулахууд руу зөвшөөрөлгүй гадны хүн нэвтрэхийг хориглодог ба үйлдвэр агуулахын цогцолбор нь 24 цагийн харуул хамгаалалтын хяналт, хамгаалалтад байдаг. | Үйл ажиллагааны явцад тогтмол хяналт тавин ажилладаг | Дотоод зардал |
| Агуулахад хадгалж буй бодисын ангилал, нэр төрөл, тоо хэмжээг тусгасан байнгын бүртгэлтэй байна. | Химийн бодис болон тэсэрч, дэлбэрэх бодисын орлого, зарлагын бүртгэлийг агуулах болон бодис тус бүрээр тухай бүр хөтөлж баримтжуулан ажилладаг | Үйл ажиллагааны явцад тогтмол хяналт тавин ажилладаг | Дотоод зардал |

**Химийн бодисыг тээвэрлэх:**

| 2022 онд Байгаль орчныг хамгаалах чиглэлээр хийхээр төлөвлөсөн арга хэмжээ | 2021 онд хийж хэрэгжүүлсэн ажлын гүйцэтгэлийн тайлан | Гүйцэтгэсэн хугацаа | Нийт зардал,₮ |
|---|---|---|---|
| Химийн хорт болон аюултай бодисыг техникийн болон аюулгүйн шаардлага хангасан тээврийн хэрэгслээр тээвэрлэж уг тээврийн хэрэгсэлд анхааруулах тэмдэг, аюулын шинж чанарын тухай санамж байрлуулна. /2022 оны БОМТ-нд 100,000.00 төгрөг төсөвлөсөн/ | Химийн бодис тээвэрлэх тусгай зөвшөөрөл бүхий тээврийн хэрэгслийн тэмдэг тэмдэглэгээг сайжруулах, шинээр тэмдэг тэмдгэлгээ хийлгэх болон машины бэлэн байдлыг хангах ажлыг тухай бүр хийж хяналт тавин ажиллаж байна. | Үйл ажиллагааны явцад тогтмол хяналт тавин ажилладаг | Машины тэмдэг тэмдэглэгээ шинэчлэх 1,200,000.00 |
| Химийн бодисыг тээвэрлэж буй авто машины жолооч, ажилтнуудад химийн бодис тээвэрлэж байгаа талаар тодорхой мэдээлэл өгч байхаас гадна тээвэрлэхдээ аюул осол гарсан үед яаралтай ямар арга хэмжээ авах талаар зааварчлагааг тухай бүр өгнө. | Химийн бодис тээвэрлэх үед тухайн химийн бодистой холбоотой аюулгүй ажиллгааны зааварчилгаа болон хор аюулын талаархи мэдээллийг тухай бүр өгч ажилладаг. | Тээвэрлэлт хийх бүрт | Дотоод зардал |
| Химийн хорт болон аюултай бодис тээвэрлэсний дараа тээврийн хэрэгсэлд сайтар угаалга, цэвэрлэгээ хийж, зохих шаардлагын дагуу хоргүйжүүлэх арга хэмжээ авч аюулгүй болгоно. /2022 оны БОМТ-нд 100,000.00 төгрөг төсөвлөсөн/ | Үйлдвэрт химийн бодис ачиж ирсэн аливаа тээврийн хэрэгслийг машин угаах цэгт цэвэрлэгээ, угаалгыг бүрэн хийсний дараа засвар, үйлчилгээ болон дараачийн ажилд гаргах бэлтгэлийг хангах арга хэмжээг авч ажилладаг. | Үйл ажиллагааны явцад тогтмол хяналт тавин ажилладаг | Ариутгал цэвэрлэгээний бодис, хамгаалах хучлага, татлага гэх мэт 200,000.00 |
| Тээвэрлэлтийн явцад химийн бодисыг болгоомжтой зөөвөрлөж замын донсолгоонд унаж савалгаа нь гэмтэх, хаяг шошго нь унахаас сэргийлэн сайтар бэхэлгээ даруулга хийсэн байх шаардлагатай. /2022 оны БОМТ-нд 100,000.00 төгрөг төсөвлөсөн/ | Тээвэрлэлтэд явах бүр техникийн механик, жолооч нар бүрэн үзлэг хийж гаргадаг ба гэнэтийн үед бэлэн байдалд ашиглах нөөц татлага, хучлагыг бэлтгэн өгдөг. | Тээвэрлэлт хийх бүрт | Нөөц материал бэлтгэхэд 200,000.00 |

**Химийн бодисыг ашиглах:**

| 2022 онд Байгаль орчныг хамгаалах чиглэлээр хийхээр төлөвлөсөн арга хэмжээ | 2022 онд хийж хэрэгжүүлсэн ажлын гүйцэтгэлийн тайлан | Гүйцэтгэсэн хугацаа | Нийт зардал,₮ |
|---|---|---|---|
| Химийн хорт болон аюултай бодис ашиглахтай холбоотой үйл ажиллагаар хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны нөхцөл, шаардлагыг бүрэн хангасан зориулалтын байр, талбайд тогтмол явуулна. БОМ төлөвлөгөөнд (200,000.00) | Тэсрэх бодисын үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд ашиглагдаж буй химийн бодисуудын хүн болон байгаль орчинд учруулах аливаа аюул, эрчдээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг тухай бүр авч хэрэгжүүлэн ажилтнуудыг шаардлагатай хамгаалах хэрэгслээр бүрэн хангаж, ажлын байрны хяналтыг тогтмол сайжруулан, анхаарч ажиллаж байна. | Үйл ажиллагааны явцад тогтмол хяналт тавин ажилладаг | Дотоод зардал |
| Химийн хорт болон аюултай бодис ашиглах явцад тухайн ажлын байр болон байгаль орчинд эрх бүхий байгууллагаас тогтоосон химийн хорт болон аюултай бодисын хүлцэх хэмжээг хэтрүүлэхгүй байхад анхаарч, хэрэгжүүлэн ажиллана. | Хөдөлмөрийн Аюулгүй Байдал Эрүүл Мэндийн Төвтэй тогтмол хамтран ажиллаж Хөдөлмөрийн нөхцлийн үнэлгээ хийлгэдэг ба тус үнэлгээний хяналтаар химийн бодисын аюулгүй байдлыг хэрхэн хангаж байгаа талаархи мэдээлэл баталгаажуулагдан гардаг болно. Мөн үйл ажиллагааны явцад өөрийн үйлдвэрлэлийн дотоод хяналтыг тогтмол хийдэг. | 2022 оны 7-р сард хэмжилтийн ажлыг хийлгэсэн. | Дотоод зардал |
| Химийн хорт болон аюултай бодистой харьцах ажилд мэргэжлийн зохих мэдлэг, дадлага туршлагатай 18-аас дээш настай хүнийг ажиллуулна. | Компанийн хүний нөөцийг бэлдэхдээ холбогдох хуулийн дагуу 18-аас дээш настай хүнийг авч ажиллуулдаг ба ажилчдыг аюулгүй ажиллагааны сургалт, зааварчилгаанд тогтмол хамруулдаг. | Үйл ажиллагааны явцад тогтмол хэрэгжүүлэн ажилладаг | Дотоод зардал |
| Химийн хорт болон аюултай бодистой харьцах үйлдвэрийн ажилчдад аюулгүй ажиллагаа, болзошгүй осол, эрсдлээс сэргийлэх болон анхны тусламж үзүүлэх сургалтыг компани дотооддоо болон холбогдох журамд заасны дагуу мэргэжлийн байгууллага /хүн/-аар зохион байгуулгуулж, хамтран ажиллана. /2022 оны төсөвт 300,000.00/ | Химийн бодисын хор, аюулын талаар дотоод доо нийт ажилтанд сургалт зохион байгуулан ажилласан. | Химич инженерийн ажилтан сургалтыг явуулсан. | - |

| | | | |
|---|---|---|---|
| Химийн хорт болон аюултай бодис ашиглах явцдаа байгаль орчинд болон ажлын байранд зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс хэтэрсэн бохирдол гаргасан тохиолдолд бохирдлыг бууруулах, арилгах, саармагжуулах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. БОМТөлөвлөгөөнд 600,000.00 | Химийн бодисын агуулах тус бүрт болон үйлдвэрийн лабораторид гэнэтийг үед шууд авч хэрэглэх зориулалттай иж бүрдлийг байршуулсан. | Үйл ажиллагааны явцад тогтмол хэрэгжүүлэн ажилладаг. | Сөрөг нөлөөллийг бууруулах зардалд тусгагдсан. |

**Химийн бодисыг устгах:**

| 2022 онд Байгаль орчныг хамгаалах чиглэлээр хийхээр төлөвлөсөн арга хэмжээ | 2022 онд хийж хэрэгжүүлсэн ажлын гүйцэтгэлийн тайлан | Гүйцэтгэсэн хугацаа | Нийт зардал,₮ |
|---|---|---|---|
| Химийн хорт болон аюултай бодисын хаягдлыг холбогдох мэргэжлийн байгууллагын дүгнэлтийг үндэслэн сум, дүүргийн Засаг даргаас тогтоосон цэгт хүний эрүүл мэнд, байгаль орчин, мал, амьтанд хоргүй буюу аюулгүй аргаар Химийн хорт болон аюултай бодис хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгах журмын дагуу устгана. /2022 оны БОМТ-нд 300,000.00 төгрөг төсөвлөсөн/ | 2022 онд химийн Сум орон нутагт устгах хог хаягдал гараагүй болно. | Үйл ажиллагааны явцад тогтмол хэрэгжүүлэн ажилладаг. | Тус асуудалд төсөвлөсөн зардал гараагүй болно. |
| Химийн хорт болон аюултай бодис хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгах төлөвлөгөөний нийт төсөв: | 2022 оны нийт төсөв: 1,050,000.00 | 2022 онд химийн хорт болон аюултай бодис хадгалах, тээвэрлэх, ашиглахад зарцуулсан зардал | 5,200,000.00 |

### 3.7. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт:

**Ахуйн гаралтай хог хаягдал:**

| 2022 онд Байгаль орчныг хамгаалах чиглэлээр хийхээр төлөвлөсөн арга хэмжээ | 2022 онд хийж хэрэгжүүлсэн ажлын гүйцэтгэлийн тайлан | Гүйцэтгэсэн хугацаа | Нийт зардал,₮ |
|---|---|---|---|
| Хог хаягдлын цэгт ариутгал, халдваргүйжүүлэлтийг тогтмол хийх, хаягдлыг эрүүл ахуй, ариун цэврийн зохих шаардлага, стандартыг мөрдөн ажиллана. /2022 оны БОМТ-нд 200,000.00 төгрөг төсөвлөсөн/ | Ахуйн хог хаягдлыг удаан хугацаанд хадгалахгүйгээр хогийн цэг рүү ачуулдаг ба хогийн цэг орчмын ариутгалыг зориулалтын ариутгалын бодисоор тогтмол хийдэг. | Үйл ажиллагааны явцад тогтмол хийдэг. | “Тэгш дүүрэн тохижилт”ОНӨААТҮГ-ын тооцоор 3,420,000.00 |
| Хатуу хаягдлыг зайлшгүй ялган сортолж зохих хэсгүүдийг (цаас, хуванцар, шил лонх, яс, төмөр, төмөрлөгүүд, хүнсний органик хаягдал гэх мэт) хоёрдогч түүхий эдийн цэгт тушаах, ангилан ялгаж сортолсон хэсгийг тусгай уут саванд хадгалах, ангилсан хаягдал агуулах нэмэлт хогийн савнууд суурилуулна. /2022 оны БОМТ-нд 100,000.00 төгрөг төсөвлөсөн/ | Хатуу хаягдлыг шаардлагын дагуу ангилан байршуулж хоёрдахь түүхий эд авах газарт хүлээлгэн өгдөг. | Үйл ажиллагааны явцад тогтмол хийдэг. | Хогийн сав авах, хоёрдогч түүхий эд зөөх гэх мэт 1,500,000.00 |
| Хогийн сав болон хог хаях цэгийн багтаамж, хүчин чадлаас хамааруулан тогтсон графикийн дагуу хог хаягдлыг тээврлэн сумаас зааж өгсөн цэгт хаях. | Зуны улиралд 2-3 хоногт сумын төвийн хогийн цэгт ахуйн хог хаягдлыг зөөж хаядаг. | Дотоод зардал | Дотоод зардал |
| Ажиллагсдын бие засах газар, нийтийн хоолны цэгээс гарах шингэн хаягдлыг бохирын цооногт хуримтлуулан, тогтмол хугацаанд ариутгал, халдваргүйжүүлэлтийг хийж байна. /2021 оны БОМТ-нд 200,000.00 төгрөг төсөвлөсөн | Ажилчдын бие засах газрын болон хоолны шингэн хаягдлыг 2-3 хоногт тогтмол соруулж цэвэрлэх байгууламжид нийлүүлдэг. Ариутгал, халдваргүйжүүлэлтийг өнжөөд нэг удаа тогтмол хийж байна. | Үйл ажиллагааны явцад тогтмол хийдэг. | Дотоод зардал |

**Үйлдвэрлэлийн болон тусгай хог хаягдал**

| Байгаль орчныг хамгаалах арга хэмжээ | Хамрах хүрээ | Нийт зардал (мян.төг) | Хэрэгжүүлэгч |
|---|---|---|---|
| Гэнэтийн болон шаардлага гарсан тохиолдолд химийн хорт бодисыг устгах үйл ажиллагаар зохих шаардлагын дагуу мэргэжлийн байгууллагын заавар, зөвлөмж, туслалцаатай гүйцэтгэнэ. | Шаардлага гарсан тохиолдолд | Дотоод зардал | Төслийн менежер, ХАБЭАБО ажилтан, Химич- инженер Агуулахын нярав |
| Химийн бодис агуулсан шингэн хаягдлыг хөрсөнд нэвчүүлэхгүй байж, хальж асгарахаас сэргийлэн хяналт тавьж ажиллах ба хамтран ажиллах гэрээний дагуу “Ухаа-Худаг” цэвэрлэх байгууламжид тухай бүр нийлүүлэн ажиллана. | Тухай бүр | Дотоод зардал | Төслийн менежер, ХАБЭАБО ажилтан, Химич- инженер супервайзер, операторууд |
| Химийн бодисын хоосон сав, уутыг зохих стандарт шаардлагын дагуу хоргүйжүүлэх , дахин ашиглах боломж нөхцлийг тогтмол судлан хэрэгжүүлж ажиллана. | Төсөл хэрэгжих шатанд | Дотоод зардал | Төслийн менежер, ХАБЭАБО ажилтан Химич- инженер Агуулахын нярав |
| Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний нийт зардал 2021 оны төлөвлөв | Хог хаягдлын менежментийн нийт төсөвт: 500,000.00 | | Нийт төсөв: 12,000,000.00 |

### 3.7 Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт

| Орчин | Байгаль орчныг хамгаалах арга хэмжээ | Тайлбар | Баримт хавсралт |
|---|---|---|---|
| Ахуйн гаралтай хог: | Хог хаягдлын цэгт ариутгал, халдваргүйжүүлэлтийг тогтмол хийх, хаягдлыг эрүүл ахуй, ариун цэврийн зохих шаардлага, стандартыг мөрдөн ажиллана. | “Тэгш Дүүрэн” ХТГ хийсэн гэрээний дагуу хогийн цэгт хаяж устгадаг. | - |
| | Ажиллагсдын бие засах газар, нийтийн хоолны цэгээс гарах шингэн хаягдлыг бохирын цооногт хуримтлуулан, тогтмол хугацаанд ариутгал, халдваргүйжүүлэлт болон шугам хоолойн засвар, үйлчилгээг цаг тухай бүр хийж байна. | Тухай бүр | - |
| | Хатуу хаягдлыг зайлшгүй ялган сортолж зохих хэсгүүдийг (цаас, хуванцар, шил лонх, яс, төмөр, төмөрлөгүүд, хүнсний органик хаягдал гэх мэт) хоёрдогч түүхий эдийн цэгт тушаах, ангилан ялгаж сортолсон хэсгийг тусгай уут саванд хадгалах, ангилсан хаягдал агуулах нэмэлт хогийн савнууд суурилуулна. | Хог хаягдлыг ангилан ялган ялган хадгалдаг | |
| Үйлдвэрийн гаралтай хог: | Гэнэтийн болон шаардлага гарсан тохиолдолд химийн хорт бодисыг устгах үйл ажиллагааг зохих шаардлагын дагуу мэргэжлийн байгууллагын заавар, зөвлөмж, туслалцаатай гүйцэтгэнэ. | Орон нутгийн Цагдаагийн байгууллага, МХГ, ОБГ, Тагнуулын ажилтан зэргийг байлцуулан устгаж дүгнэлт гарган МХЕГ-т тайлагнана. 2022 онд шаардлага гараагүй. | - |
| | Химийн бодис агуулсан шингэн хаягдлыг хөрсөнд нэвчүүлэхгүй байж, хальж асгарахаас сэргийлэн хяналт тавьж ажиллах | Шингэн бохир тээвэрлэх гэрээтэй байгууллагатай хамтран шингэн бохир нийлүүлэн ажилласан. | - |
| | Химийн бодис агуулсан шингэн хаягдлыг хөрсөнд нэвчүүлэхгүй байж, хальж асгарахаас сэргийлэн хяналт тавьж ажиллах. | “Цэцүүх Трейд” ХХК-д хүргэн өгч устгуулдаг. | |

### 3.8 Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт:

Манай компани нь Монгол улсын нутаг дэвсгэрт хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа холбогдох хууль, дүрэм, журам, стандартуудыг үйл ажиллагаандаа дагаж мөрдөн, тогтмол хяналт тавин ажиллаж байна.Энэхүү шаардлагын хүрээнд манай улсын, цаашлаад олон улсын уул уурхайн үйлдвэрлэл, үйлчилгээ болон байгаль орчныг хамгаалах үйл ажиллагааны хөгжлийн чиг хандлагатай уялдан удирдлагын болон үйл ажиллагааны тогтолцоог шинэчлэх, хамтрагч байгууллагуудын хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн ажиллах нь нэн тэргүүний үүрэг болон илэрч байна.Үүнтэй уялдуулан компанийн хариуцлагыг өндөржүүлэх үүднээс 2017 онд ISO 9001:2015 Чанарын менежментийн тогтолцоог болон OSHAS 18001:2012 Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын удирдлагын тогтолцоог нэвтрүүлэхээр хэрэгжүүлж эхлэн ажиллаж байна. Цаашдаа манай компани ирэх онуудад ISO 14001 байгаль орчны удирдлагын тогтолцоог үйл ажиллагаандаа нэвтрүүлэх зорилт тавин, төлөвлөн ажиллаж байна. 2022 онд тэсрэх бодисын үйлдвэрлэлийн үйл ажиллагаа хэвийн явагдсан ба үйл ажиллагааны онцлогтой холбогдуулан байгаль орчинд нөлөөлөх аливаа сөрөг нөлөөллийг бууруулах, эрсдлийг багасгах чиглэлд тайланд тусгасан ажлуудыг хийж гүйцэтгэн ажиллаа.

1. Байгаль орчны хууль, журмын хэрэгжлийлтийг хангах зорилгоор ажлын байруудад дотоод хяналт шалгалтаар улиралд 1 удаа үзлэг шалгалт хийдэг.
2. Хог хаягдал тээвэрлэх эрх бүхий компани, хувь хүнтэй гэрээ байгуулан шингэн бохир болон хатуу хог хаягдлыг тээвэрлэн устгах газар нь устгуулан ажилладаг.
3. Өмнөговь аймгийн нутагт ургадаг эмийн ургамлын судалгаанд дэмжлэг үзүүлэх мөнгөн хөрөнгийг шийдвэрлэн ажилласан.
4. Байгаль хамгаалах тэмдэглэлт өдрийн хүрээнд дэлхийн усны өдрийг нөхөж тэмдэглэн Мөрөөдөл цэцэрлэгийн хүүхдүүдийн дунд зургийн уралдаан мөн Мөрөөдөл цэцэрлэгт 100ш боллантай усыг хандивлан эрүүл суралцах боломжоор хангаж өгөв.

### 3.9 Олон нийтэд тайлагнах хуваарь, төлөвлөгөөний биелэлт

“Спейшл майнинг сервис” ХХК нь жил бүр Байгаль Орчны Менежментийн Төлөвлөгөөний хэрэгжилтийн талаар байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тайлан хүргүүлэн, хянуулан ажиллаж байгаа ба байгаль орчны хяналтын улсын байцаагч, орон нутгийн байцаагч нарт газар дээр нь болон тайлан танилцуулах байдлаар шалгуулан ажиллаж ирсэн болно. 2022 онд холбогдох хуулийн дагуу Байгаль Орчны Аудитыг хийлгэсэн ба тус аудитаар гаргасан зөвлөмжийн дагуухь шаардлагуудын биелэлтийг энэхүү тайланд хавсралтаар оруулан тайланд тусгав.Өнгөрсөн жилүүдэд үйлдвэрлэлийн үйл ажиллагаа улс орны нийгэм, эдийн засгийн байдлаас шалтгаалан хэвийн бус, тогтворгүй байдалтай ажиллаж байснаас шалтгаалан сум, багийн иргэд, иргэдийн хуралд компанийн үйл ажиллагааны талаар болон байгаль орчны асуудлаар танилцуулж байгаагүй болно.Үйл ажиллагааны онцлогоос шалтгаалан орон нутгийн удирдлага, бусад мэргэжлийн байгууллагуудтай / ЗДТГ, Цагдаагийн хэлтэс, Онцгой Байдлын Хэлтэс гэх мэт / нягт хамтран ажиллаж ирсэн ба цаашид ч сум, орон нутгийн иргэд, удирдлагууд, мэргэжлийн байгууллагуудтай тогтмол хамтран ажиллахад илүү анхааран ажиллана. Энэ оноос

Цогтцэций сумын Цагаан-Овоо багийн болон сумын төвийн иргэд, иргэдийн нийтийн хуралд компанийн үйл ажиллагааны онцлог, цар хүрээ, байгальд орчинд үзүүлэх үйлдвэрлэлийн хүчин зүйлийн болзошгүй эрсдэл, түүнээс хамгаалах арга хэлбэр, хяналт, удирдлагын тогтолцооны талаархи мэдээллийг танилцуулах боломжгүй цар тахлын үед Олон нийтийг хамарсан цуглаан уулзалт зохиогдоогүй болно.

### 3.10 Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр, түүний үр дүнг тайлагнах, хэлэлцүүлэх төлөвлөгөөний биелэлт

Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр нь төслийн үйл ажиллагааны нөлөөлөлд өртөх болон өртөж болзошгүй байгаль орчны бүрдэл хэсгүүд, тэдгээрийн төлөв байдлыг тодорхойлох үзүүлэлтүүд, төсөл хэрэгжих орчинд амьдардаг, төслийн нөлөөлөлд өртөх нутгийн иргэдийн амьжиргаа, нийгмийн болон эрүүл мэндийн байдлыг илтгэх гол үзүүлэлтүүд, тэдгээрт хэмжилт дээжлэлт хийх шинжилгээний аргууд, хяналтын цэгийн байршил, хяналт хийх хугацаа ба давтамж зэргийг бүхэлд нь тусгасан Байгаль Орчинд Нөлөөлөх Байдлын Нарийвчилсан Үнэлгээний чухал хэсэг юм.

**Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний хэрэгжилтийн дэлгэрэнгүй тайлан**

**Агаарын чанар хэвийн байлгах хүрээнд авсан арга хэмжээ:**

1. Манай компани нь кемпээс тэсрэх бодисын үйлдвэр орох, буцах үйлдвэрээс уурхай орох, буцахдаа батлагдсан маршрутын дагуу тухайн замаар зорчихыг мөрдлөг болгодог ба өөр зам гаргахгүй байх талд тогтмол хяналт тавьж ажилладаг.
2. "Спейшл Майнинг Сервис" ХХК-нь тэсрэх бодисын үйлдвэрээс уурхай руу тээвэр хийх замын маршрутыг Өмнөговь аймгийн Цогтцэций сумын цагдаагийн хэлтэсээс тогтоож өгсний дагуу ЦЕГ-ын Бүртгэл Хяналтын төвд хүсэлт гарган батлуулж зөвхөн тус маршрутын дагуу аюулгүй байдлыг бүрэн хангаж тээвэрлэлтийн ажлыг гүйцэтгэж байна.
3. Үйлдвэрийн технологи хэвийн үйл ажиллагааг хангах зорилгоор ямар нэгэн техникийн эвдрэл гэмтэл гарахаас сэргийлж технологи бүр дээрхи техникийн эд ангиудын насжилт, гадныг хүчин зүйлс, цахилгааны хэлбэлзэл зэрэг нөлөөлж болох хүчин зүйлсүүдийг байнга шалгаж үйлдвэр эхлэх, үйлдвэрлэл явагдаж байх, үйлдвэр унтраах энэ бүх үед мэргэжлийн цахилгаанчин, оператор байнга шалгаж тухай бүр хяналтын хуудсан дээр бүртгэл хөтөлж, ямар нэгэн өөрчлөлт гарсан тохиолдолд үйлдвэрийг зогсоож гэмтэл согогийг арилгасны дараагаар үйлдвэрийг ажиллуулдаг болно. Ингэж ажилласнаар эвдрэл гэмтэл гарч байгаль орчин бохирдуулах, ажилчид гэмтэх, эд хөрөнгийн ноцтой хохирол гарах зэрэг эрсдэлээс бүрэн урьдчилан сэргийлэх давуу талтай юм.
4. Төслийн хэмжээнд хэрэглэгдэж байгаа техник хэрэгслүүдээс ялгарах утаа нь байгаль бохирдуулах нэг томоохон хүчин зүйл юм. Манай компани нь тэсрэх бодис тээвэрлэх, түүний түүхий эдийг тээвэрлэх зэрэг эрсдэл өндөртэй үйл ажиллагаа эрхэлдэг учир техник, хэрэгслүүдийн хөдөлгүүрт түлш бүрэн шатаж байгаа эсэх , гадагш утаа, цог хаяулахгүй байх тал дээр бүрэн

анхаарч мэргэжлээрээ олон жил ажилласан автын механик инженерүүдийг ажиллуулан техник хэрэгсэлийн эвдрэл гэмтлийг гаргахгүй байхад бүх талаар анхаарч, тогтмол хяналт тавин ажиллаж байна. Монгол улсын хэмжээнд явагддаг техникийн улсын үзлэгт идэвхтэй оролцон өөрийн эзэмшлийн бүх техник, хэрэгслийн хөдөлгүүрээс гарч байгаа утааг шалгуулан зохих татварыг төлж, техник хэрэгслийг ашиглаж болно гэсэн зөвшөөрлийг авдаг. Үйлдвэрийн орчинд болон түүхий эдийн битүү агуулахын орчинд ажиллах хөдөлгөөнт төхөөрөмжөө дотоод шаталтад хөдөлгүүргүй, цахилгаанаар цэнэглэж зайгаар ажилладаг сэрээт өргөгчийг сонгож хэргэлсэнээр битүү орчинд утаа хуримтлагдах нөхцөлийг үгүй болгосноороо давуу талтай юм.

5. Салхи шуурга ихтэй, орчны байдлаас шалтгаалсан тоосжилт ихтэй үед ажилчдын ажиллах орчныг сайжруулах чиглэлээр үйлдвэрийн хашаан доторхи зам, талбайг ус шүршиж чийглэж, норгох, услах арга хэмжээг дулааны улиралд авч хэрэгжүүлэн ажилладаг.
6. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн хүрээнд 2022 оны 7-р сард Өмнөговь аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний газарт хүсэлт гарган орчин дахь тоосжилтын хэмжилтийг салхины зонхилох чиглэлийн доод талаас хийлгэж, дүгнэлт гаргуулан ажиллаа. Тус дүгнэлтийг хавсралтад тусгав.

**Газрын гадрага, хөрс хамгаалах үйл ажиллагааны хүрээнд хийгдсэн ажлууд:**

1. Олон салаа зам гаргахгүй зорилгоор зөвхөн батлагдсан маршрутын дагуу “Эрдэнэс Таван Толгой”ХК болон “Тавантолгой”ХК уурхай явдаг технологийн замаар тээвэрлэлтийн ажлыг гүйцэтгэж байгаа болно.




2. Үйлдвэр, агуулахын орчин тойронд болон кемпийн орчинд, түүнчлэн өөр бусад газарт зориулалтын хогийн цэгээс гадагш буюу ил задгай газарт ямар нэгэн элдэв хог хаяхгүй, газрын хөрсийг хөндөхгүй байхад анхаарч байгаль орчны талаархи сургалт зохион байгуулж хог хаягдал гарах бүх газарт хогийн сав байрлуулж, хогийг ангилан хийхэд сургах, дадал суулгах, энгийн хог, дахин ашиглах хог зэргийг таниулан мэдүүлэхэд тогмол анхаарч, хэрэгжүүлэн ажиллаж байна.





3. Байгалийн давагдашгүй олон хүчин зүйлсийн нэг бол гал түймрийн аюул юм. Говийн бүс нь харьцангуй тарүу ургамалтай хэдий ч бидний эрхэлж байгаа ажил тэсэрч, дэлбэрэх бодис үйлдвэрлэдэг учир энэ асуудалд хойрог хандаж болохгүй нь зүйн хэрэг билээ. Иймд гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлж үйлдвэрийн хашааг тойруулан галын аюулаас хамгаалах бүс 2:0,5 метр хэмжээтэй  татсан байдаг ба жил бүр тус бүсийг тогтмол сэргээж, тухайн орчныг цэвэрлэх ажлыг тухай бүр хийж байна.




Тэсрэх бодисын үйлдвэрийн хашаан доторхи талбайд хөрсний бохирдлыг хянах зорилгоор болон 2022 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт тусгасны дагуу 2022 оны 9-р сард Өмнөговь аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний газарт хүсэлт гарган үйлдвэрийн орчны газрын хөрсний бохирдлын хэмжилтийг хийлгэж, дүгнэлт гаргуулан ажиллаа. Тус дүгнэлтийг хавсралтад тусгав.

5. Химийн бодис болон тос, тослох материал хадгалалтын явцад асгарч, гоожих, үүнээс шалтгаалан химийн бодис, техникийн тос, тосолгооны материал хөрсөнд алдагдахаас сэргийлж агуулах, талбайн үзлэг, шалгалтыг тогтмол хийдэг бөгөөд энэхүү эрсдлээс сэргийлэх үүднээс агуулахын доторхи шал болон агуулахын гадна талбай, тос хадгалах талбай зэргийг бүрэн цементийг засаж янзлан ажиллаа. Хөрс саармагжуулах талбай, Тос асгарахаас сэргийлсэн тос хуримтлуулах цэг байгуулагж ажилласан.









**Гадаргын болон газрын доорхи ус хамгаалах арга хэмжээний хүрээнд хийгдсэн ажлууд:**

1. Байгалийн давагдашгүй хүчин зүйлийн нэг бол үер усны аюул юм. Гэхдээ үүнд урьдаас бэлтгэлтэй байснаар аливаа эрсдэл үүсч, хохирол учрахаас урьдчилан сэргийлэх боломжтой юм. Манай компани нь химийн бодис ашиглаж үйл ажиллагаа, үйлдвэрлэл явуулдаг учраас үер, усны гамшиг тохиолдсон үед байгаль орчинд болон хүн ам зүй, амьтан ургамалд хохирол учруулах эрсэдлтэй юм.Ийм ч учраас үйлдвэр, агуулахын “Гамшгаас хамгаалах төлөвлөгөө”-нд тусгасны дагуу газрын хэвгийн дээд талаар буюу үер буух магадлал өндөртэй хэсгээр 1,5 метрийн өндөртэй хамгаалалтын даланг барьж байгуулсан болно.




2. Үйлдвэрлэл, хадгалалтын явцад химийн бодис хөрсөнд нэвчиж, цаашлаад гүний усанд уусахаас сэргийлж агуулахын шал, агуулахын гадна талбай, үйлдвэрийн шал зэргийг бүрэн цементлэх, резенин будгаар битүү будах зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлсэн бөгөөд хадгалалт, үйлдвэрлэлийн үеийн хяналтыг тухай бүр хариуцлагатайгаар хийж ажиллаж байна.




3. Үйлдвэрлэлд хэрэглэгдэж байгаа химийн бодисуудыг тус тусд нь агуулахад хадгалж, агуулах тус бүрт байгаа химийн бодисуудын Хор аюулын лавлах мэдээллийг /ХАЛМ/ агуулахын хаалган дээр хэвлүүлсэн самбарыг байршуулсан шинэчлэн болно. Энэ нь тус бодистой харьцаж ажиллах ажилтнууд, хяналт, шалгалтын ажлаар яваа байцаагч нарт тус бодисын талаар бүрэн мэдээлэл авах, аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлэх, аюул, ослын үед хэрхэн ажиллах зэрэг бүрэн мэдээллийг авах чухал ач холбогдолтой юм.




4. Хөрсний бохирдол газар доорхи усанд нөлөөлөх эрсдлээс сэргийлж химийн бодис асгарах, түлш тос асгарах үед хэрэглэх иж бүрдэл болон хорт бодисыг саармагжуулах бүтээгдхүүнийг авч хадгалж ажилласан.






5. “Спейшл Майнинг Сервис" ХХК-нь химийн бодисын асгаралт хаягдлын менежментийг боловсруулан даган мөрдөж ажилладаг. Аливаа эрсдлээс урьдчилан сэргийлэхийн тулд байнгын хяналтад байлгах, аюултай орчин үүсгэхгүй байх, анхаарал болгоомжтой, өндөр хариуцлагатай ажиллах нь хамгаас чухал гэдгийг нийт ажилтнуудад тогтмол зааварлан үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажилладаг болно. Манай үйлдвэрт 6 нэр төрлийн химийн бодис ашигладгаас 2 төрлийн химийн бодисын асгаралт, хаягдлыг саармагжуулах зааврыг оруулав.

### Ammonium nitrate waste management

| | |
|---|---|
| **Химийн бодисын нэр/ name /** | Ammonium nitrate |
| **Гадаад байдал** | Үнэргүй, цайвар шаргал 1-3 мм мөхлөг хэлбэртэй |
| **Процент:** | 99.9% |
| **№ UN** | 1942 |
| **Дөл авалцах температур (FP)** | $135^0$C |
| **Савлагдсан байдал** | 1000кг |
| **Харьцахад шаардагдах нэмэлт ХХХ** | Амны хаалт ашиглах, ажлын бээлий, зузаан арьсан битүү гутал. Хамгаалалтын битүү нүдний шил |

Хаягдалын процесс

| № | Асгаралт хаягдал цуглуулах арга | Саармагжуулах Аюулгүй болгох | Устгах, дахин ашиглах |
|---|---|---|---|
| Үйлдвэрийн шал, контейнер дотор асгарсан | Цэвэрхэн хэсгийг шууд хэрэглэх. Чулуу шороотой хэсгийг 1 т-ын уутанд хуримтлуулж авна. | Шаардлагагүй | 1 т-ын уутай хаягдлыг зориулалтын газар хадгалана. Аммиакийн шүү нь ургамал газар тариаланд химийн бордоогоор ашиглаж болох тул компаний менежментээр зохицуулагдана. |

| | | | |
|---|---|---|---|
| | | | Гологдлыг тэсэлгээний талбайд тэсэлж устгана. |
| Гадаа̀ талбай, газарт асгарсан | Цэвэрхэн хэсгийг шууд үйлдвэрт хэрэглэх. Чулуу шороотой хэсгийг 1 т-ын уутанд хуримтлуулж авна. | Шаардлагагүй | 1 т-ын уутай хаягдлыг зоруулалтын газар хадгалана. Аммиакийн шүү нь ургамал газар тариаланд химийн бордоогоор ашиглаж болох тул компаний менежментээр зохицуулагдана. Гологдлыг тэсэлгээний талбайд тэсэлж устгана. |
| Үйлдвэрлэлийн процесс зөрчигдөснөөр тохиолдох шингэн асгаралт, гологдол | Асгаралтûã 25 хүртэлх кг-аар тэсэлгээнд хэрэглэдэг зориулалтын пластик уутанд савлаж цэвэрхэн 1000кг-н хуванцар саванд хийнэ | Шаардлагагүй | 1000кг-н хуванцар савтай хаягдлыг зориулалтын газар тусад нь хуримтлуулах ба тэсэлгээний талбайд тэсэлж устгана. |
| | Гологдол эмульсийг 25 хүртлэх кг-аар тэсэлгээнд хэрэглэдэг зориулалтын пластик уутанд савлаж цэвэрхэн 1000кг-н хуванцар саванд хийнэ | Шаардлагагүй | 1000кг-н хуванцар савтай хаягдлыг зориулалтын газар тусад нь хуримтлуулах ба тэсэлгээний талбайд тэсэлж устгана. |

Үйлдвэрлэлээс гарсан хоосон уут, савыг хаях

| Сав, уут | Хадгалах | Хаях, устгах |
|---|---|---|
| 1 т-ын хоосон уут | 1 т-ын шүүний уутанд хийнэ. 1 т-ын уутанд савлагдсан хогыг бусад хогноос тусад нь зохих газар хуримтлуулна. | Холбогдох мэргэжлийн байгууллагуудын заавар, зөвлөмжийн дагуу устгал хийнэ. |

**Sodium nitrite Waste management**

| | |
|---|---|
| **Химийн бодисын нэр /name /** | /Sodium nitrite/<br>Additive 1, UG additive |
| **Гадаад байдал** | Үнэргүй,цагаан талст бодис |
| **Процент:** | 99% |
| **№ UN** | 1500 |
| **Дөл авалцах температур (FP)** | 160ºC |
| **Савлагдсан байдал** | 25кг |
| **Харьцахад шаардагдах нэмэлт ХХХ** | Хамгаалах амьсгалын аппарат ашиглах<br>Урт ханцуйтай зузаан резинэн бээлий, хормогч, зузаан арьсан битүү гутал.<br>Хамгаалалтын битүү нүдний шил, хорт хийн баг |

Хаягдалын процесс

| № | Асгаралт хаягадал цуглуулах арга | Саармагжуулах Аюулгүй болгох | Устгах, дахин ашиглах |
|---|---|---|---|
| Үйлдвэрийн шал, контенер дотор асгарсан | Том бүхэл цэвэрхэн хэсгийг шууд хэрэглэх. Чулуу шороотой хэсгийг цэвэр хуванцар саванд хуримтлуулж авна. | Хуримтлуулсан саван дахь бодисын 1:9 харьцаагаар болгоомжтой усан дээрээс хийнэ. pH-г 5.5-7.0 бариулна. | Уг уусмалыг хөдөлгөөнгүй газар уусмалыг тунгаан шүүж авна. Шүүж авсан уусмалыг нэмэлт-1 найруула̀хад усны дүнд оруулж ашиглах, тундасыг байгаль орчны хэлтэсѐ мэдэгдэж бохирдсон хөрс хаях цэгт асгана |
| Гадаа талбай, газарт асгарсан | Том хатуу хэсгийг нь түүж шууд хэргэлэх. Газарт шигдсэн хэсгийг шороо чулуу аль болох | 1:9 харьцаагаар ус нэмж pH-г 5.5-7.0 бариулна. | Уг уусмалыг хөдөлгөөнгүй газар тунгаан шүүж авна. Шүүж авсан уусмалаа нэмэлт-1 үйлдвэрлэлд усны дүнд оруулж ашиглах, |

| | | | |
|---|---|---|---|
| | багатай авч цэвэр саванд нарийн тороор шигшиж хийнэ. | | тундасыг байгаль орчины хэлтэсд мэдэгдэж бохирдсон хөрс хаях цэгт асгана |
| Үйлдвэрлэлийн процесс зөрчигдөснөөр тохиолдох шингэн асгаралт, гологдол | Шингэн асгаралтыг цэвэрхэн хуванцар саванд хуримтлуулж авна. | Шаардлагагүй | 1000кг-н хуванцар савтай хаягдлыг зориулалтын газар тусд нь хадгалах ба хурдан хугацаанд тэсэлгээний талбайд тэсэлж устгана. |
| | Голгодлыг 25 хүртлэх кг-аар тэсэлгээнд хэрэглэдэг зориулалтын пластик уутанд савлаж цэвэрхэн 1000кг-н хуванцар саванд хийнэ | Шаардлагагүй | 1000кг-н хуванцар савтай хаягдлыг зориулалтын газар тусд нь хадгалах ба хурдан хугацаанд тэсэлгээний талбайд тэсэлж устгана. |

Үйлдвэрлэлээс гарсан хоосон уут, савыг хаях

| Сав, уут | Хадгалах | Хаях, устгах |
|---|---|---|
| 25кг хоосон уут | Зориулалтын хуванцар хогийн саванд хийнэ. Сав дүүрсэн тохиолдолд маш сайн цэвэрлэсэн 1 т-ын уутанд хийж тусад нь хадгална. | Уг хаягал уутыг сумын захиргаанаас тогтоосон газарт шатааж устгана.. |

6. Үйлдвэрийн үйл ажиллагааны явцад гарсан бохир усыг түр хадгалах зориулалттай хаягдлын цэгийг орон нутгийн удирдлага, Байгаль орчны хяналтын байцаагч нарт танилцуулан зохих зөвшөөрлийг аван ашиглаж байна. Тус хаягдлын түр цэг нь газар ухаж, битүү бетондож доторлосон байгууламжид 25тн-ын ёмкость байрлуулж хийсэн бөгөөд үйлдвэрээс гарсан бохир ус зориулалтын хоолойгоор дамжин тус ёмкостод хуримтлагдана. Өмнөговь аймгийн Цогтцэций сумын Засаг даргын “Хог хаягдлын түр цэг байгуулах тухай” А/190 тоот Захирамжаар зөвшөөрсөн цэгт хуримтлуулдаг.





7. Ахуйн бохир зайлуулах шугамыг стандартын шаардлагад нийцсэн гадагш хөрсөнд нэвчихээргүй хуванцар хоолойг зангидаж зориулалтын төмөр танканд хуримтлуулан өдөр бүр ариутгал хийн ажилласан.



8. “Спейшл майнинг сервис”ХХК-нь 2017 онд өөрийн эзэмшлийн хашаан дотор үйлдвэрлэлтийн зориулалтаар ашиглах гүний худгийг мэргэжлийн байгууллагаар гаргуулж холбогдох зөвшөөрөл, дүгнэлтийг Өмнөговь аймгийн БОГ-аар гаргуулан

Цогтцэций сумын байгаль хамгаалагчид хянуулан баталгаажуулсан тоолуур тавьж хуулийн дагуу тус худгийг ашиглаж эхлээд байсан. 2022 онд Тоолуурын баталгаажуулалтыг Өмнөговь аймгийн Хэмжилзүйн газраар баталгаажуулсан.


СТАНДАРТ, ХЭМЖИЛ ЗҮЙН ГАЗАР

УСНЫ ТООЛУУРЫН
БАТАЛГААЖУУЛАЛТЫН ГЭРЧИЛГЭЭ

№ 00228964

Спейшл Майнинг ХХК-д
(хэрэглэгчийн нэр)

ашиглаж байгаа DH загварын 3,5м³/ц хэмжих хязгаартай, 25 мм-ийн голчтой № 1703000038-ын халуун, хүйтэн усны тоолуурыг № 116 лацаар битүүмжилж
(доогуур зурах)

2024 оны 06 -р сарын 16 –ны өдөр хүртэл улсын баталгаажуулалтын гэрчилгээ олгов.

Шалгалтын дараах заалт: 23122 м³

Лабораторийн тэмдэг

Усны шалгагчийн гарын үсэг, тэмдэг

2022 оны 06 –р сарын 16 -ны өдөр

**Ургамлан нөмрөг хамгаалах чиглэлээр хийгдсэн ажил:**

Үйлдвэрлэлийн талбайн зөвшөөрөл авсанаас хойших хугцаанд үйлдвэрийн талбайн гаднах хэсэгт газар хөндөх ямар нэгэн ажил хийгдээгүй учир энэ жил газар хөндөх зөвшөөрөл авах шаардлага гараагүй ба ийм шаардлага гарсан тохиолдолд мэргэжлийн байгууллагаас зохих зөвшөөрөл авч монгол улсын хууль, дагалдах тогтоолуудыг үндэслэн стандартын дагуу хийж гүйцэтгэх болно.

**Амьтны аймаг хамгаалах чиглэлээр хийгдсэн ажлууд:**

Монгол улсын улаан ном, бүс нутгийн болон олон улсын улаан дансанд бүртгэлтэй ховордсон, нэн ховордсон зэрлэг ан, амьтны талаар төслийн хүрээнд ажиллаж байгаа нийт ажилчдад сургалт зохион байгуулж тэдгээрийг устгах агнахыг хориглодог талаар болон хүлээлгэх хариуцлагын талаар мэдээллийг өгч ажиллаж байна. Үйлдвэрийн орчин тойрон нь төв, суурин газартай ойрлцоо /сумын төвөөс 7км/, машин, техникийн хөдөлгөөн ихтэй /ЭТТ-н уурхай явах зам дагуу/ газарт байрладаг тул зэрлэг ан, амьтан байх, нутагших боломжгүй газар юм. Гэвч Цогтцэций сумын байгаль хамгаалагчтай хамтран  Зэрлэг ан амьтан суурьшсан "Хар дэл" нэртэй газар Биотехникийн арга хэмжээнд оролцов.









**Байгаль орчныг хамгаалах хүрээнд баримтлах бодлого**

1. Одоо бид байгаль орчинд ээлтэй бодит ажлуудыг тасралтгүй гүйцэтгэж, сайжруулж, энэхүү гэрчилгээг авах зорилго тавин, ажиллаж байна.

Байгаль орчны менежментийн системийн бодлого.

Байгууллагын менежментийн тогтолцооны салшгүй нэг хэсэг нь байгаль орчны бодлогыг сайжруулах, түүнийг хэрэгжүүлэх, мөн байгаль орчинд ээлтэй үйлдвэрлэл явуулж, эх дэлхий хүрээлэн буй орчноо хайрлан, хамгаалах явдал юм.

- Байгаль орчны сөрөг нөлөөллийг бууруулах бодлогыг тогтмол сайжруулах
- Нөөц баялагийн ашиглалт болон хаягдал бүтээгдэхүүний ялгаруулалтыг багасгах. Ингэснээр тодорхой хэмжээнд бүтээмжээ дээшлүүлж, зардлаа хэмнэх боломжтой юм.
- Хэрэгжиж буй холбогдох хуулийн болон бусад байгаль орчны шаардлагуудтай үйл ажиллагаагаа байнга нийцүүлэн ажиллах
- Нийгэмд өрсөлдөх чадвартай, хэрэглэгчдийн шаардлагыг хангахуйц давуу талыг бий болгох
- Байгаль орчны талаархи хувь хүн, ажилчдын ухамсар, мэдлэгийг дээшлүүлэх
- Төр, захиргааны болон хамтран ажилладаг бусад байгууллага, түншүүд, ажилтнууд болон хувьцаа эзэмшигчдийнхээ дунд нэр хүндтэй, найрсаг харилцаатай байхад оршино.

Байгаль орчны талаар барьж байгаа бодлого нь тасралтгүй сайжрах тойрог хэлбэрийн мөчлөгтэй бөгөөд уг тогтолцооны амжилттай хэрэгжих эсэх нь бүхий л үе шат, үйл ажиллагааны гүйцэтгэл дэх хариуцлагаас хамаарна.



**Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний биелэлт:**

1. Үйлдвэрийн хашаан доторхи хөрс шороо бохирдол тоосжилт үүсгэж болзошгүй зам талбайд хайргаар хучилт хийж тоосжилтнын эсрэг арга хэмжээг байнга авч ажилладаг.




2. Үйлдвэрийн барилга, байгууламж, зам талбайд эвдэгдсэн газруудын хөрсийг нөхөн сэргээх ажлыг өмнөх жилүүдэд хийж гүйцэтгсэн бөгөөд жил бүр тордох, сайжруулах ажлыг хийж байна.




2017 онд үйлдвэрийн хашаан дотор химийн бодис ачсан машиныг болон эмульстрак, анфотракын цэвэрлэгээ хийхэд зориулсан машин угаах талбайг хийж байгуулсан 2022 онд байнга цэвэрлэж засаж янзлан хайрга тойруулан асгаж энэ талбай руу ороход гарах замын эвдрэл тоосжилтыг арилгах арга хэмжээ авч ажилласан.

3. Үйлдвэрийн бүтээн байгуулалт явагдаж байх үеийн хөрсний эвдрэл, гэмтлийг арилгах, тэсэрч дэлбэрэх бодисын агуулахын галын аюулгүй байдлыг хангах зорилгоор жил бүр арчилж, тордох ажлыг тогтмол хийж байна.




4. 2022 оны Байгаль Орчны Менежментийн Төлөвлөгөөнд тусгаснаар мод, бут тарихаар төлөвлөсний дагуу тэсрэх бодисын үйлдвэрийн хашааны урд талбайд 3000ш говийн нөхцөлд ургах боломжтой, тэсвэр сайтай хайлаас мод тарьж ургуулан, арчилгаа, усалгааны ажлыг тогтмол хийж байна.



5. Төслийн үйл ажиллагаа эхэлснээс хойшхи хугацаанд төслийн талбайд ховор, нэн ховор ургамал илрээгүй тул нүүлгэн шилжүүлэх, хамгаалах, хашилт, хаалт байршуулах шаардлага гараагүй болно.
6. Сумын БО, Сумын хамтын ажиллагааны гэрээнд тусгагдсаны дагуу “Спейшл Майнинг Сервис”ХХК-ний зардлаар Сумын төвийн гудамж талбайд байрлуулах 6ш савыг авч суманд хүргүүлсэн.





НХМаягт БМ 2

Сангийн сайдын 2017 оны 12 дугаар сарын 5 өдрийн 347 тоот тушаалын хавсралт

**ОРЛОГЫН БАРИМТ №** 55

Дагалдах баримт №

*Спейшл Майнинг Сервис ХХК*
(байгууллагын нэр)

2021 он 04 сар 10 өдөр

*ЮНИЛАНД ХХК*
(бэлтгэн нийлүүлэгчийн нэр)

*хогийн сав 4ш орлогот*
(гүйлгээний утга)

| № | Материалын үнэт зүйлийн нэр, зэрэг, дугаар | Код | Хэмжих нэгж | Нэг бүрийн үнэ | Хүлээн авсан | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Тоо | Үнэ |
| 1 | Хогийн сав 270л, 120л | 60241 | ш | 181,818.1800 | 4 | 727,272.7200 |
| | | | ӨРТӨГ | | 4 | 727,272.7200 |
| | | | НӨАТ | | | 72,727.2800 |
| | | | НИЙТ | | | 800,000.0000 |

Тэмдэг

Хүлээн авсан - - - - - - - - - - - - - - - - - - - -

Хүлээлгэн өгсөн - - - - - - - - - - - - - - - - - -









**Химийн бодисыг хадгалахтай холбогдуулан авсан арга хэмжээ:**

1. Химийн бодисыг зориулалтын агуулахад агааржуулалттай, сүүдрэвчтэй орчинд хадгалж, тухайн орчны температур, агааржуулалтыг тогтмол хянаж байдаг. Химийн бодисуудыг зөвхөн үйлдвэрийн химич-инженерийн захиалгаар агуулахын нярав гаргаж өгөх ба бусад нөхцөлд агуулахаас ямарч химийн бодис гардаггүй. Химийн бодис болон Түүхий эдийн 3ш агуулахыг барьж улсын коммист хүлээлгэн өгч ашиглалтанд оруулсан.







/ Химийн бодисын агуулахыг зураг төслийн дагуу зориулалтын агуулах барьсан/









2. Химийн бодисын агуулах тус бүрийн хаалган дээр хадгалагдаж байгаа химийн бодисын нэр, Хор Аюулын Лавлах Мэдээлэлийг /ХАЛМ/ байршуулсан бөгөөд энэ нь аюулгүй байдлыг хангаж ажиллахад харьцаж ажиллаж байгаа ажилчидад нэн чухал шаардлагатай зүйл юм.




/Химийн бодисын агуулахуудад байрлуулсан ХАЛМ /

3. Тэсрэх бодис болон тэслэх хэрэгслийг, нарны шууд тусгалаас хамгаалсан, агааржуулалттай, аянга, цахилгааны эх үүсгүүрээс хамгаалагдсан аянга зайлуулагчтай стандартын агуулахад хадгалдаг. Аянга зайлуулагчны газардуулгыг сайжруулах ажил хийгдсэн.



4. Агуулахын нярваас өөр хүн химийн бодисын агуулахыг нээх дотороос нь химийн бодис гаргахыг хоргилох ба шаардах хуудас, үйлдвэрийн даргын зөвшөөрөлтэйгөөр химийн бодисыг гаргана. Агуулахын нярав нь химийн бодис бүр дээр нарийвчилсан бүртгэл хөтлөдөг ба тухайн химийн бодисыг гарсан он, сар, өдөр, буцаалт зэргийг хөтөлж давхар онлайн хэлбэрээр программд оруулсанаар Улаанбаатар хот дахь оффисын нягтлан бодогч, удирдлагууд тогтмол хянаж байдаг.

**Тэсэрч дэлбэрэх бодис болон химийн бодисыг тээвэрлэх үед авах арга хэмжээ:**

1. “Спейшл майнинг сервис” ХХК-нь тэсрэх материалын болон химийн бодисын тээвэрлэлтийг тусгай зөвшөөрөлтэй өөрийн компанийн тээврийн хэрэгслээр гүйцэтгэж байна.Тэсрэх материалыг тээвэрлэхдээ ЦЕГ-ын Бүртгэл Хяналтын төвөөс олгосон маршрутын дагуу цагдаагийн хамгаалалттай тусгай зөвшөөрөл бүхий тээврийн хэрэгслээр тээвэрлэдэг.Шаардлагатай буюу шаардлага гарсан тохиолдолд тусгай зориулалтын тээврийн хэрэгслээр буюу тус үйлчилгээг

үзүүлэх боломжтой байгууллага, компаниар химийн бодисын тээвэрлэлтийг хийлгэх төлөвлөгөөтэй ажилладаг.

2. Химийн бодис тээвэрлэж байгаа авто машины жолооч нарт ямар төрлийн химийн бодис тээвэрлэж байгаа, гэнэтийн ослын үед ямар арга хэмжээ авах, асгаралт гоожилт гарсан үед авах арга хэмжээний талаар сургалт зохион байгуулж тухайн химийн бодисыг дагалдуулан Хор Аюулын Лавлах Материал / ХАЛМ/ -ыг дагалдуулан өгдөг.
3. Химийн бодис тээвэрлэсний дараагаар тээврийн хэрэгслийг бүрэн цэвэрлэж, хоргүйжүүлсний дараагаар үйлдвэрийн хашаанаас гадагш гаргадаг. Асгаралт, гоожилт жолоочийн буруу ачсанаас, гэнэтийн ослоос гэх мэт шалтгаанаар үүсэх магадлалтай байдаг. Асгаралт гарсан тохиолдолд усан буугаар шүршин цэвэрлэж, саармагжуулж химийн бодистой усыг хуванцар саванд хуримтлуулж зориулалтын газар хаяна. Гэхдээ тухайн тээврийн хэргэслийн тээвэрлэх хэсгийг сайтар цэвэрлэсний дараагаар дахин тээвэрт гаргана.
4. Тээвэрлүүлэгч, тээвэрлэгч талуудын хооронд байгуулсан гэрээн дээр химийн бодис нь өөр өөрийн онцолгоос шалтгаалан шатамхай, мэдрэмтгий, байгаль орчин болон хүн амьтанд хортой байдаг тул түүнийг асгарч гоожих, цоорхоос сэргийлж битүү контейнерон бүхээгтэй болон тэвшийн нь бүрэн доторлосон машинд, нарны гэрлийн шууд тусгал, салхи, шуурга, цас, бороонoос хамгаалж бүтээлэг хэргэлэн хөдөлгөөнгүй сайтар баглаж тээвэрлэхийг сануулсан байдаг.

**Химийн бодисыг ашиглах үед авсан арга хэмжээ:**

1. Манай компанийн үйлдвэр агуулахын цогцолбор нь хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааг бүрэн хангасан тохилог үйлдвэрлэлийн орчин юм.

Хувийн хамгаалах хэрэгслийг төрөл хуваарийн дагуу тараах хугацаа.

| № | Хувийн хамгаалах хэрэгсэл | Тоо хэмжээ | Хугацаа |
|---|---|---|---|
| 1 | Малгай / Каск / | 1 | Жил |
| 2 | Нүдний шил | 2 | 14 хоног |
| 3 | Ажлын битүү цамц | 2 | Улиралд |
| 4 | Ажлын өмд | 2 | Улиралд |
| 5 | Хамгаалалтын гутал | 2 | Жилд |
| 6 | Ажлын бээлий | 1 | Өдөр |
| 7 | Маск | 5 | Өдөр |
| 8 | Хорт хийн баг | 2 | Жилд |
| 9 | Хүчил шүлтэд тэсвэртэй резинэн бээлий | 4 | Жилд |

2. Тэсрэх бодисын үйлдвэр нь хортой, шатамхай химийн бодис ашиглаж тэсрэх бодис үйлдвэрлэдэг. Манай үйлдвэрт ашиглаж байгаа зарим химийн бодис нь байгаль орчин, хүн, амьтанд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй тул үйлдвэрийн агааржуулалтийн системийг маш сайн шийдэж өгсөн.

Үйлвэрийн таазанд нийт 1 метрийн диаметртэй 4-н агааржуулах хоолой гарган байнгын ажиллагаанд байлгадаг. Үйлдвэр доторхи жижиг өрөөнүүдийн агааржуулах систем нь тусдаа бөгөөд агааржуулах хоолойгоор холбогдон гадагш гардаг.

Үйлдвэр агуулахын дотор агааржуулалт





3. Тэсрэх бодисын үйлдвэрт ажиллана гэдэг бол маш өндөр хариуцлага ноогдох ажил юм. Нэг буруу үйлдэл гаргаснаар хүний амь, нас, байгаль орчин, эд хөрөнгийн маш их хохирол учруулах магадлалтай учир хүний нөөцийн бодлого дээрээ маш хариуцлагтай ханддаг.Төслийн хэмжээнд ажиллах ажилчдаа холбогдох хуулийн дагуу 18-аас дээш настай, шаардлагатай мэргэжил эзэмшсэн, ажилдаа нямбай, зохих дадлага туршлагтай, буруу зуршилгүй хүнийг авч ХАБЭА-н болон бусад холбогдох хууль, дүрэм, журмын дагуу сургалтад хамруулан ажилуулдаг.Нийт ажилчдад заавал хамруулах сургалтаас гадна үйлдвэрлэлийн үйл ажиллагаатай болон хүрээлэн буй байгаль орчныг хамгаалах, гамшиг ослын эрсдлээс урьчилан сэргийлэх зэрэг сургалт, зааварчилгааг тогтмол өгч ажилладаг.





4. Химийн бодисын асгаралт, гоожилт цэвэрлэх, саармагжуулах арга. Химийн бодис тус бүр дээр асгаралтыг саармагжуулах арга боловсруулсан бөгөөд шаардлага гарсан тохиолдолд тус арга хэлбэрээр саармагжуулах арга хэмжээ авна.Үйлдвэрлэлийн үйл ажиллагаа явагдсан өнгөрсөн хугацаанд химийн бодис, алдагдах, гоожих түүнтэй холбоотой аливаа аюул, эрсдэлтэй байдал үүсээгүй болно.

| **Химийн бодисын нэр / name/** | Acetic acid |
|---|---|
| **Гадаад байдал** | **Цууны хүчил**<br>Хурц, цоргисон үнэр бүхий өнгөгүй шингэн |
| **Процент:** | Шоргоолжны хүчил: 98%<br>Цууны хүчил: 80% |
| **№ UN** | Шоргоолжны хүчил: 1779<br>Цууны хүчил: 2789 |
| **Дөл авалцах температур (FP)** | Шоргоолжны хүчил: 49,95$^{o}$C<br>Цууны хүчил: 39.5 $^{o}$ C |
| **Савлагдсан байдал** | Шоргоолжны хүчил: 25кг торх<br>Цууны хүчил: 30кг, 200кг торх |
| **Харьцахад шаардагдах нэмэлт ХХХ** | Амьсгалын аппарат ашиглах<br>Урт ханцуйтай зузаан резинэн бээлий, хормогч, зузаан арьсан, резинэн гутал<br>Хамгаалалтын нүдний битүү шил, хорт хийн баг |

Хаягдалын процесс

| № | Асгаралт хаягадал цуглуулах арга | Саармагжуулах Аюулгүй болгох | Устгах, дахин ашиглах |
|---|---|---|---|
| Үйлдвэрийн шал, контейнер дотор асгарсан | Усаар булхаж усыг цэвэр хуванцар торхîîä хуримтлуулж авна. Энэ үйлдлийг 3 удаа давтан хийнэ. | Цэвэрлэгээнээс хуримтлуулж авсан уусмалын pH-г шалгаж хүчиллэг байвал pH-г 5.0-7.0 хооронд болтол ус нэмнэ. | Уг уусмалыг хөдөлгөөнгүй газар тунгаан шүүж авна. Шүүж авсан уусмалаа менежерийн зөвшөөрлөөр нэмэлт 2-г найруулахад усны дүнд оруулж ашиглах, тундасыг байгаль орчны хэлтэст мэдэгдэж бохирдсон хөрс хаях цэгт асгана |
| Гадаа талбай, газарт асгарсан | Нэвчсэн газартай нь хуулж цэвэр хуванцар торхонд хийж авна | 9:1 харьцаагаар болгоомжтой усан дээрээс хийнэ. pH-г 5.5-7.0 болтол ус нэмж хийнэ. | Уг уусмалыг хөдөлгөөнгүй газар байлгаж тунгаан шүүж авна. Шүүж авсан уусмалаа менежерийн зөвшөөрлөөр нэмэлт 2-г найруулахад усны дүнд оруулж ашиглах, тундасыг байгаль орчины хэлтэст мэдэгдэж бохирдсон хөрс хаях цэгт асгана |
| Нэмэлт 2-ийн үйлдвэрлэлийн процесс зөрчигдөснөөр тохиолдох шингэн асгаралт, гологдол | Асгаралтыг цэвэр хуванцар саванд хуримтлуулж авна | Шаардлагагүй | Сайтар тунгаан шүүж авна.Шүүж авсан уусмалыг менежерийн зөвшөөрлөөр нэмэлт 2-ã найруулахад дахин ашиглах, тундасыг 9:1 харьцаагаар усан дээр хийж дахин тунгаан шүүж авсанаар байгаль орчны хэлтэст мэдэгдэж бохирдсон хөрс хаях цэгт асгана |
| | Гологдолыг цэвэрхэн хуванцар саванд хийж авна.<br>25 хүртэлх кг-аар тэсэлгээнд хэрэглэдэг зориулалтын пластик уутанд савлаж цэвэрхэн 1000кг-н хуванцар саванд хийнэ | Шаардлагагүй | Уусмалыг менежерийн зөвшөөрлөөр хувь, процентийг тааруулж нэмэлт 2 найруулахад дахин ашиглах áà 25кг,1000кг-н хуванцар савтай хаягдлыг зориулалтын газар тусд нь хуримтлуулах ба тэсэлгээний талбайд тэсэлж устгана. |

Үйлдвэрлэлээс гарсан хоосон савыг хаях

| Сав, уут | Саармагжуулах<br>Аюулгүй болгох | Хаях, устгах |
|---|---|---|
| 25кг хоосон торх | Торхны 1/10 –ээр ус хийж саармагжуулан усыг юүлж авна. | Төслийн хогийн цэгийн хуванцар сав хуримтлуулах хэсэгт өгнө. |

**Ахуйн гаралтай хог хаягдлаас байгаль орчин хамгаалах арга хэмжээ:**

1. Хог хаягдлын цэг байгуулж тухайн хогийг ялган ангилж Цогтцэций сумын “Тэгш Дүүрэн” ОНӨААТҮГ-тай хийсэн гэрээний дагуу 7 хоногт 1-2 удаа хогийн цэг рүү зөөж асгадаг.Мөн үйлдвэрийн бүс орчмын болон кемпийн хашааны орчмын хогийг тогтмол цэвэрлэн байгаль орчноо цэвэр, цэмцгэр байлгахад анхаарч ажиллаж байна.
2. Ахуйн хаягдлыг тус тусд нь ялган хийх зориулалттай хогийн савыг байршуулж анх хийхдээ ялган хаяснаар дахин ашиглах хоёрдогч түүхий эд / төмөр, шил, хуванцар сав, гэх мэт/ зэргийг тус тусад нь хуримтлуулж хоёрдогч түүхий эд авах цэгт тушаадаг.



3. Манай кемп нь ажилчдын тав тухтай байх бүхий л нөхцөл бололцоог хангах үүднээс суултуур, дүүш зэргийг байрлуулсан бөгөөд эндээс гарсан бохирыг түр хадгадлах бохирын танканд хуримтлуулж 7 хоногт 2-3 удаа соруулан цэвэрлэх байгууламжид зөөж хаядаг. Тус бохирын түр цэгийн дулааны улиралд 3%-ийн хлормины уусмалаар тогтмол ариутгаж, ариутгал халдваргүйжүүлэлтийн арга хэмжээг тогтмол авч хэрэгжүүлэн ажиллаж байна.





**Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт:**

“Спейшл Майнинг Сервис”ХХК-нь химийн бодис ашиглан тэсэрч, дэлбэрэх бодис үйлдвэрлэдэг онцгой обьект болохын хувьд дараахь арга хэмжээг тогтмол хэрэгжүүлэн, хяналт тавин ажиллаж байна.Үүнд.

1. Химийн бодисын хадгалалт, хамгаалалтыг стандартын дагуу хийж тогтмол хяналт тавин ажилладаг.
2. Хэрэглэж буй химийн бодисуудын Хор Аюулын Лавлах Мэдээлэл / ХАЛМ/-ийг химийн бодис тус бүрээр гаргаж агуулахуудад байршуулсан.
3. Нийт ажилтнуудад химийн бодисын хор, аюул, түүнтэй хэрхэн зөв харьцах, хамгаалах талаар сургалт зохион байгуулж мэдлэг, чадварыг сайжруулах арга хэмжээг тогтмол хэрэгжүүлэн ажиллаж байна.
4. Байгаль орчныг хамгаалах болон үйлдвэрлэлийн үйл ажиллагаанаас шалтгаалан байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл, эрсдэлтэй хүчин зүйлс, тэдгээрээс хэрхэн урьчилан сэргийлэх, хамгаалах талаар сургалтыг нийт ажилчдад хийж холбогдох арга хэмжээг тухай бүр авч ажиллаа.
5. Химийн бодисоос хамгаалах нэг бүрийн болон тусгай хувцас хэрэгслээр тогтмол хангаж ажилладаг.
6. Химийн бодистой харьцаж ажиллах ажилчдад зориулсан “Үйлдвэрлэлд хэрэглэгддэг химийн хорт бодисын хураангуй лавлах”-ыг боловсруулан үйл ажиллагаандаа тогтмол хэрэглэн ажиллаж байна.
7. Тэсрэх бодисын үйлдвэрийн дамжлага тус бүрийн стандарт ажлын журмыг боловсруулан батлуулж мөрдлөгө болгон ажиллаж байна.
8. “Тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгслүүдийн хураангуй лавлах”-ыг боловсруулан үйл ажиллагаандаа тогтмол хэрэглэн ажиллаж байна.

9. Эзэмшил газрын төлөв, байдлыг хадгалах, байгаль орчинд нөлөөлөх нөлөөллийг бууруулах ажлыг үйлдвэрлэлийн явцад тогтмол хийж хэрэгжүүлэн ажилласан.Жишээ нь: Үйлдвэрийн хашаан доторхи автозамыг хашилттай болгосон, химийн бодисын агуулахын гадна талбайг бүрэн цементэлсэн, машин угаах талбайг цементлэн бохир усыг хаягдлын цэг рүү шууд урсгаж оруулах зохион байгуулалттайгаар байгуулсан, дизель түлшний агуулахын дээд талыг бүрэн цементлэн аюулгүй байдлыг хангах болон байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулсан гэх мэт ажлууд хийгдсэн /
10. Холбогдох хуулийн дагуу эзэмшил газарт 500м2 талбайд мод, бут тарьж ургуулсан ба цаашид жил бүр нэмэж ургуулахаар төлөвлөн ажиллаж байна.
11. Өөрийн эзэмшлийн бүсд үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглах гүний худаг гаргуулж холбогдох зөвшөөрлүүдийг авсан.
12. Ашиглаж буй машин, техникүүдийн засвар, үйлчилгээ, оношлогоог тухай бүр хийж тодорхой хэмжээгээр байгаль орчинд нөлөөлөх сөрөг нөлөөллийг бууруулахад анхаарч ажиллаж байна.

**Байгаль орчны сургалтын ерөнхий агуулга**

**"Спейшл Майнинг Сервис"ХХК-ний Өмнөговь аймгийн Цогтцэций сумын нутагт байрлах Үйлдвэрийн зориулалттай тэсрэх бодисын үйлдвэрийн Ажлын байран дахь сургалт зааварчилгааны бүртгэл /Байгаль орчныг хамгаалах, сөрөг нөлөөллийг бууруулах талаар/**

| № | Анхан шатны зааварчилгаа авсан хүний овог, нэр | Албан тушаал | Зааварчилгааны утга | Он, сар, өдөр | Зааварчилгаа өгсөн хүний овог, нэр , албан тушаал ,гарын үсэг | Зааварчилгаа авсан хүний гарын үсэг | Ажиллуулахыг зөвшөөрсөн хүний | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Албан тушаал овог нэр | Гарын үсэг |

"Спейшл Майнинг Сервис"ХХК-ний Өмнөговь аймгийн Цогтцэций суманд байрлах Тэсрэх бодисын үйлдвэрийн ажилтануудад хүрээлэн буй байгаль орчныг хамгаалах, байгальд сөрөг нөлөө үзүүлэх аливаа үйлдлийг таслан зогсоох, зүй бус үйлдэл гаргахгүй байх, сөрөг нөлөөллийг бууруулахад байнга анхаарах, өөрсдийн амьдарч, ажиллаж буй орчноо байнга хайрлан хамгаалах, байгаль орчинд ээлтэй үйл ажиллагаа явуулсны ашиг тусын талаар доорхи сургалтыг зохион байгуулав.Байгаль орчинд хор хөнөөл учруулах аливаа үйлдэл нь эргээд ямар нэгэн хэмжээгээр сөрөг нөлөөлөл үүсгэж байдаг.Тус үйлдвэрийн үйл ажиллагаанд хүнд болон байгаль орчинд хортойгоор нөлөөлөхүйц химийн бодисуудыг ашиглаж байгаа тул үйлдвэрийн технологийн процесст оролцон ажиллаж байгаа нийт ажилтанууд / хими-технологич, үйлдвэрийн супервайзерууд, үйлдвэрийн оператор, туслах ажилтан, цэнэглэгч машины оператор, жолооч / нь өдөр тутмын үйл ажиллагаандаа маш анхаарлтай хандаж, аливаа эрсдэл үүсгэхээс ямагт урьдчилан сэргийлж ажиллах үүрэг хүлээнэ.Технологийн дэс дараалал, орц нормыг зөвшөөрөгдөх хэм хэмжээнд баримтлан ажиллаж, ямар нэгэн алдаа, эндэгдэл гарсан даруйд удирдах ажилтан, ХАБ-ын ажилтануудад яаралтай мэдэгдэж үнэн зөв мэдээллээр хангаж ажиллах үүрэгтэй.Химийн бодис алдагдаж газарт шингэснээр гүний усанд шингэх, газрын гадрага, хөрсний ургамалд нөлөөлөх түүнчлэн агаар бохирдуулах зэрэг замуудаар хүн, амьтанд нөлөөлөх аюултайг анхаарч өөрсдийн үүрэг хариуцлагыг цаг ямагт ухамсарлан хариуцлагатай ажиллана.Тээврийн хэрэгслээр зорчиход болон уурхайд тэсрэх материал нийлүүлэхээр явахдаа зөвхөн батлагдсан маршрут, зөвшөөрөгдсөн технологийн замаар хөдөлгөөний хурдыг заасан хэмжээнд баримтлан их хэмжээний тоос,шороо үүсгэхгүйгээр аюулгүй байдлыг бүрэн хангаж анхаарал болгоомжтой хөдөлгөөнд оролцоно.Үйлдвэрийн бүсд гарсан хог хаягдлыг зөвхөн зориулалтын хогийн саванд хийж тогтсон хугацаанд төвлөрсөн хогийн цэг рүү зөөж байна.Химийн бодисын сав, баглаа боодлыг ариутгал, саармагжуулалт хийхгүйгээр хэрэглэх, хаяхыг хориглоно.Химийн бодисыг хэрэглэх, найруулах үедээ байнга хамгаалах баг зүүж ажиллана.Кемп, болон үйлдвэрийн бүсд зөвхөн зориулалтын хогийн саванд ахуйн хог хаяж байх, зориулалтын зөвшөөрөгдсөн газарт тамхи татахыг зөвшөөрне.Үйлдвэрийн нийт ажилтанууд нь байгаль орчинд хор хөнөөл үүсгэж болохуйц аливаа зөрчил, дутагдлыг тэр дариуд засаж, тогтмол хяналт тавьж ажиллах үүрэг хүлээнэ.

**Хавсралт-1:** 2016 онд “Спейшл Майнинг Сервис”ХХК-ний Тэсрэх бодисын үйлдвэрийн Байгаль орчныг нөхөн сэргээхэд зарцуулах барьцаа мөнгийг БОАЖЯамны Төрийн сангийн тусгай дансанд байршуулсан баримт.

**ХААН БАНК** МӨНГӨН ШИЛЖҮҮЛЭГ/MONEY TRANSFER

| ОН/YYYY | САР/MM | ӨДӨР/DD |
|---|---|---|
| 2016 | 12 | 26 |

Хүлээн Авагчийн/Recipient's

| Банкны нэр, байрлал/Bank name&Location | Дансны №/Account No: | Нэр (байгууллага эсвэл иргэн)/Name(of organization's or individual) |
|---|---|---|
| :Торийн сан | 900013406 | БО нохон сэргээх баталгаа |

| Дүн тоогоор/Amount: | Дүн үсгээр/Amount in words |
|---|---|
| *4,000,000.00+* | *дорвон сая тогрог* |

| Валютын код/Currency code: | Гүйлгээний утга, бусад тэмдэглэл/Transaction description& other notes: | Гүйвуулгын код/Code: |
|---|---|---|
| MNT | СПЕЙШЛ МАЙНИНГ СЕРВИС ХХК РД-5623529 БО БАРЬЦАА | 0 |

Шилжүүлэгчийн/Sender's

| Валютын код/Currence code: | Дансны №/Account No: | Нэр(байгууллага эсвэл иргэн)/Name(of organization's or individual) |
|---|---|---|
| MNT | 5029178565 | НОЁН ОВГИЙ НАРАНБААТАР |

| Дүн тоогоор/Amount: | Дүн үсгээр/Amount in words |
|---|---|
| *4,000,000.00-* | *дорвон сая тогрог* |

| Гүйлгээний төрөл/Transaction code: | Тэмдэглэл/Note: |
|---|---|
| 1042 БАНК ХООРОНДЫН ГУЙЛГЭЭ | 5029178565 900013406 4000,000 |

Энэ баримтад бичигдсэн мэдээллийн үнэн зөвийг хариуцаж, аливаа хариуцлагыг хүлээхээ гарын үсгээр баталгаажуулав.
I, hereby, sign to confirm the accuracy of the information provided here and agree to accept any legal responsibility.

Тамга Stamp:

Гарын үсэг/Sender signature 1. ........ 2. 88114933

Банкны тэмдэглэл/For Bank use only

| Шилжүүлгийн хураамж/Fee amount | Теллер№/Teller no: | Журнал №/journal No: | Огноо/Date: | Теллер гарын үсэг/Teller signature: | Шилжүүлэгчийн биеийн байцаалтын төрөл №/Customer ID: |
|---|---|---|---|---|---|
| ☐бэлнээр/in cash ☐данснаас/form account 500 | 8027 | 1780007 | 12/26/2016 | ХААН БАНК ТЕЛЛЕР | РИ79100517 |

**ХААН БАНК** МӨНГӨН ШИЛЖҮҮЛЭГ/MONEY TRANSFER

| ОН/YYYY | САР/MM | ӨДӨР/DD |
|---|---|---|
| 2016 | 12 | 27 |

Хүлээн Авагчийн/Recipient's

| Банкны нэр, байрлал/Bank name&Location | Дансны №/Account No: | Нэр (байгууллага эсвэл иргэн)/Name(of organization's or individual) |
|---|---|---|
| :Төрийн сан | 000000900013406 | БО нөхөн сэргээх баталгаа |

| Дүн тоогоор/Amount: | Дүн үсгээр/Amount in words |
|---|---|
| *75,000.00+* | *далан таван мянган төгрөг* |

| Валютын код/Currency code: | Гүйлгээний утга, бусад тэмдэглэл/Transaction description& other notes: | Гүйвуулгын код/Code: |
|---|---|---|
| MNT | СПЕЙШЛ МАЙНИНГ СЕРВИС ХХК 5623529 БО БАРЬЦАА | 0 |

Шилжүүлэгчийн/Sender's

| Валютын код/Currence code: | Дансны №/Account No: | Нэр(байгууллага эсвэл иргэн)/Name(of organization's or individual) |
|---|---|---|
| MNT | 502917856 | НОЁН ЕВГИЙ НАРАНБААТАР |

| Дүн тоогоор/Amount: | Дүн үсгээр/Amount in words |
|---|---|
| *75,000.00-* | *далан таван мянган төгрөг* |

| Гүйлгээний төрөл/Transaction code: | Тэмдэглэл/Note: |
|---|---|
| 1054 БАНК ХООРОНДЫН ГҮЙЛГЭЭ | 5029178565 900013406 75000 |

Энэ баримтад бичигдсэн мэдээллийн үнэн зөвийг хариуцаж, аливаа хариуцлагыг хүлээхээ гарын үсгээр баталгаажуулав.
I, hereby, sign to confirm the accuracy of the information provided here and agree to accept any legal responsibility.

Тамга Stamp:

Гарын үсэг/Sender signature 1. ........ 2. 88114933

Банкны тэмдэглэл/For Bank use only

| Шилжүүлгийн хураамж/Fee amount | Теллер№/Teller no: | Журнал №/journal No: | Огноо/Date: | Теллер гарын үсэг/Teller signature: | Шилжүүлэгчийн биеийн байцаалтын төрөл №/Customer ID: |
|---|---|---|---|---|---|

**Хавсралт-2:** 2022 онд Өмнөговь аймгийн Цогтцэций сумын "Тэгш дүүрэн"ОНӨААТҮГ-тай байгуулсан "Хог хаягдлын гэрээ"

БАТЛАВ.
"ТЭГШ ДҮҮРЭН ТОХИЖИЛТ" ОНӨААТҮГАЗРЫН ДАРГА Л.ЭНХЖАРГАЛ

БАТЛАВ.
"СПЕЙШЛ МАЙНИНГ СЕРВИС" ХХК-н ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
ЗАХИРАЛ Э.АМАРСАНАА

Хог хаягдлын үйлчилгээний

тээвэрлэх гэрээ

2021 оны 12 сарын 08 өдөр № Цогтцэций сум

Нэг. Гэрээний зорилго

1.1 Сумын засаг даргатай байгуулсан гэрээний дагуу Цогтцэций сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, төсөвт болон төрийн бус байгууллагуудын ахуйн болон үйлдвэрлэлийн хог хаядлыг цуглуулж ачих, тээвэрлэх үйлчилгээний хураамжийг төвлөрүүлэхэд энэхүү гэрээний зорилго оршино.

Хоёр. Гэрээний үндэслэл

2.1. Монгол улсын засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1, 2017 оны 05 дугаар сарын 12 ны өдрийн шинэчилсэн найруулга хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйл , 10 дугаар зүйл, 14 дүгээр зүйлийн 14.2 , 41 дүгээр зүйлийн 41.1, 41.3, 41.5, 41.8, 43 дугаар зүйл Өмнөговь Цогтцэций сумын ИТХ-ын 2019 оны 5/15 тогтоолыг тус тус үндэслэн дор дурдсан нөхцөлүүдийг харилцан тохиролцож байгуулав.

2.2 Энэхүү гэрээг Нэг талаас Цогтцэций сумын Засаг даргын дэргэдэх "Тэгш дүүрэн тохижилт" ОНӨААТҮГазрыг төлөөлж Эрдэнэцогт овогтой Бужидмаа Нөгөө талаас "СПЕЙШЛ МАЙНИНГ СЕРВИС" ХХК иргэн, аж ахуйн нэгж, албан байгууллага /доогуур зурах/ уул уурхайн тэсрэх бодисын үйлдвэр, агуулах-н үйл ажиллагааны чиглэлтэй \цаашид үйлчлүүлэгч гэх\ нар харилцан тохиролцож энэхүү гэрээг байгуулав.

Гурав. Гэрээний хугацаа

3.1 2021 оны 12 сарын 08 -ны өдрөөс эхлэн 2022 оны 12 сарын 31 өдрийг дуустал хүчин төгөлдөр үйлчилнэ.

Дөрөв. Тээвэрлэгч байгууллагын эрх үүрэг

4.1 Хэрэглэгчээс хог хаягдлын төлбөрийг орон нутгийн орлогод төвлөрүүлэхийг шаардах эрхтэй.

4.2 Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг шаардах эрхтэй.

4.3 Хог хаягдлыг төвлөрсөн цэгийн үйл ажиллагааг хэвийн хэмжээнд ажиллуулах

4.4 Хогийн төвлөрсөн цэгт ирж байгаа хог хаягдлыг бүртгэх баталгаажуулах

4.5 Хогийн цэгийн хуваарийг баталж мөрдөн ажиллах байнгын сахиул ажиллуулах

4.6 Хог хаягдлыг шатаах зориулалтын талбай, хоргүйжүүлэх төхөөрөмжтэй байна.

4.7 Тухайн байгууллага нь айл өрх, иргэн, аж ахуйн нэгж, албан байгууллага, төсөвт байгууллагын хогийг ажлын 5 өдөрт 09-18 цагийн хооронд сард нэг удаа тогтсон хуваарийн дагуу ачина.

Тав. Үйлчлүүлэгчийн эрх үүрэг

5.1 Өөрийн гаргасан ахуйн болон үйлдвэрлэлийн хог хаягдлыг сумын төвлөрсөн хогийн цэгт хаях болон овор хэмжээнээс хамаарч хогны захиалгыг урд өдөр нь 88013979, 88331350 дугаарын утсанд дуудлага өгнө.

5.2 Захиалгаар болон тогтсон хуваарийн дагуу очсон тээвэрлэгч авто машиныг хоосон буцаасан, халуун үнс нурамтай, цогтой, хөлдүү хог хаягдал зэргээс шалтгаалж хог ачих, тээвэрлэх, нөхцөл боломжийг бүрдүүлээгүй тохиолдолд гарсан зардлыг тухайн аж ахуйн нэгж болон иргэн өөрөө хариуцна.

5.3 Тээвэрлэгч байгууллагад тогтсон хугацаанд, зориулалтын цэгээс уут саванд хийсэн хог хаядлыг саадгүй ачуулах үүрэгтэй.

5.4 Хог хаядлын талаарх дүрэм журам стандартын шаардлагыг хангаж ажиллах

5.5 Байгуулагын гадна хог хаягдлын зориулалтын савтай байх, өөрийн байгууллагын гаднах орчин тойрны хог хаядлыг цэвэрлэх болон хог хаягдлыг зайлуулах, олон нийтийг хамарсан ажилд оролцох үүрэгтэй.

5.6 Хог хаядлын талаарх мэдээллээ үнэн зөв мэдээллэх

Зургаа. Төлбөр тооцоо

